2021
№ 03 (37)

ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠠᠷ ᠬᠣᠲᠠ

ОНОЛ-АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



RESEARCH LINKING PRACTICE

ШҮҮХИЙН ШИЙДВЭР

ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

Онол-арга зүйн улирал тутмын сэтгүүл

Улаанбаатар

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛЬ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

УЛИРАЛ ТУТМЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

Улаанбаатар хот
2021 он

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ
Б.Нямгомбо
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн захирал, хууль зүйн доктор, хурандаа

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД
Р.Оюунбадам
Хууль зүйн доктор
Б.Алтангэрэл
Хууль зүйн доктор, дэд профессор
Ц.Очгэрэл
Хууль зүйн доктор, дэд профессор
Д.Дамдинцэрэн
Хууль зүйн доктор
Г.Баттулга
Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, хурандаа
С.Зул-Очир
Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн эрхлэгч, хурандаа
Б.Галбадрах
Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.Галбадрах
Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор

Эх бэлтгэсэн: Б.Мөнхбаатар
ШШГАС-ийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн багш, хошууч

Хэвлэлийн хуудас: _____ х/х
Хэвлэлийн тоо: _____ ш

ISBN: 978-99978-770-2-4

“ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ” СЭТГҮҮЛ

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Цагдаагийн Академийн өргөн чөлөө, Хилчний гудамж, Дотоод хэргийн Их сургууль
И-мейл: baatarmunkhbaatar@gmail.com
Веб: http://www.uia.gov.mn

ДУГААРЫН ТОВЧООН

ДУГААРЫН ТОВЧООН

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ НИЙТЛЭЛ, ӨГҮҮЛЭЛ

Д.Мягмарсүрэн
Монгол Улс ба гадаадын зарим орны хоригдолд боловсрол олгох үйл ажиллагааны өнөөгийн байдал цаашдын чиг хандлага **.....6-18**

Ч.Батболд
Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үйлдэгдэж буй гэмт явдалд хийсэн шинжилгээ **.....19-27**

Б.Отгонбаяр
Хоригдолд оногдуулах сахилгын шийтгэл, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт **.....28-37**

Б.Батзаяа
Аюулгүй байдлын онол, арга зүйн зарим асуудлууд **.....38-50**

Д.Мөнхцэцэг
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн сонгон шалгаруулалтын эрх зүйн зохицуулалт **.....51-57**

М.Даваабат
Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаан дахь хяналтын зохион байгуулалтын олон улсын туршлага **.....58-62**

Г.Балжмаа
Хорих ял эдлүүлэх ажиллагааны нийгэмшүүлэх ажлын өнөөгийн байдалд тулгамдаж буй зарим асуудал **.....63-72**

Э.Тэмүүлэн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ахлагч бүрэлдэхүүний үүрэг оролцоо, аюулгүй байдал, тэдэнд тулгамдсан зарим асуудлууд **.....73-82**

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

Уншигч, мэргэжил, зорилго нэгт Та бүхний амар амгаланг эрэн мэндчилье.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулиас уламжлал болгон эрхлэн гаргадаг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал” сэтгүүлийн 2021 оны 3 дугаар улирлын дугаарыг Та бүхэнд хүргэж байгаадаа таатай байна.

Сэтгүүлд нийтэлсэн судлаачдын судалгаа шинжилгээ, холбогдох мэдээлэл, харьцуулсан судлалын үр дүн, дүгнэлт, санал-зөвлөмжүүд асуудлыг эргэцүүлэн бодож нягтлах, шийдлийг олох, эрх зүйн орчинг боловсронгуй болгох хийгээд эрдэмжих үйлд тань хувь нэмэр оруулна гэдэгт найдан санал бодлоо илэрхийлэхийг Та бүхнээс хүсье.

Хүндэтгэсэн:

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, ДОКТОР /Ph.D/,
ХУРАНДАА Б.НЯМГОМБО

МОНГОЛ УЛС БА ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХОРИГДОЛД БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА



Д.МЯГМАРСҮРЭН
Дотоод хэргийн их сургуулийн
Ахлагчийн сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн эрхлэгч,
дэд хурандаа

Товч агуулга: Монгол Улсын хорих байгууллагын үйл ажиллагааны үндсэн нэг чиглэл нь хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх асуудал бөгөөд нэн ялангуяа гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж буй хүний үндсэн эрхийг хамгаалах, тэднийг сурч боловсрох, хөгжих боломжийг бүрдүүлж, боловсрол эзэмшүүлэх замаар нийгэмшүүлэх ажиллагааг зөв зохион байгуулах нь эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах, ялын бодлогыг нийгэм, хувь хүнд өгөөжтэй байдлаар хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Тиймээс Монгол Улсын хэмжээнд хорих ял эдлүүлэх ажиллагаа, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр батлан гаргасан эрх зүйн эх сурвалжуудад түүхчилсэн дүн шинжилгээ хийж, хоригдолд зориулсан боловсрол олгох үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тоймлон авч үзлээ.

Abstract

Түлхүүр үг: Монгол Улс, Оросын холбооны улс, Солонгос, Хорих байгууллага, Хоригдол, Боловсрол, Сургалт, Гэмт хэрэг, нийгэмшүүлэх ажил, Хүний эрх, Ялтан.

Key words

1. Монгол Улсад хорих ял эдлэгсдийн дунд явуулж байгаа сургалтын онцлог, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал

Монгол ардын намын 3-р хурлын тогтоолд Гянданаа хоригдон бүхий хэрэгтэн ардыг үйлдвэрт сургах, сургаж гэгээрүүлэх, аливаа шүүхийн тогтоолгүйгээр хэнийг ч хорихгүй байх, гяндан хорооны байдал нэн муу байгааг даруй сайжруулах, насанд хүрээгүй охид хөвгүүд хэрэгт холбогдох

аваас гянданаа хорихгүйгээр гэгээрүүлэх, аливаа хэрэгтэн ардын дотроос хүн төлөв засрах байдалтайг нь гянданаа хорихгүйгээр үйлдвэрт хийлгэвэл зохих зэргийг онцлон заажээ.[1] 1931 онд Монгол Улсын ял эдлүүлэх байгууллагын эрх зүйн түүхэн хөгжилд чухал тэмдэглэлт үйл явдал болсон нь “Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн, ялтанг засан сайжруулах ажлын тухай хууль”[2] батлагдан гарсан явдал юм.

Эндээс үзэхэд Монгол улсад хорих ял эдлүүлэх байгууллага анх үүссэн цагаасаа гэм буруутай этгээдийн эрхийг хүндэтгэн, хорихоосоо урьтаж хөдөлмөрөөр хүмүүжүүлэх, тэдэнд мэргэжил эзэмшүүлэх хөдөлмөрийн дадал олгох ажил эрчимтэй зохиох эрх зүйн үндэс 20-иод оны эхэн үеэс тавигдсан байна.

Түүхэн судалгаанаас үзэхэд хуулиудын заалтыг хооронд нь харьцуулан судлах явцад 1931,1981 онд батлагдсан хуулиудад хорих ял эдлэгсдийг сургах, тэдэнд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх талаар их дэвшилттэй заалтууд орсон гэж дүгнэж байна.

Хоригдол мэргэжил эзэмшүүлэх сургалтын ажиллагаа нь хэдийгээр агуулга, зорилтын хувьд улсын мэргэжил үйлдвэрийн сургалтын төвтэй адил төсөөтэй боловч хорих байгууллагын нөхцөлд тохирсон байдаг нь онцлог юм. Тухайлбал мэргэжлийн сургалтад хамрагдагсад нь өөрсдийн хүсэлтээр тодорхой мэргэжил эзэмшихээр элсэгчид биш, харин хорих ангид хоригдож байгаагаараа ялгаатай.

Хорих ял эдлүүлэх чиглэлээр сүүлийн үед гарсан хуулиудад “...сургалт зохион байгуулж болно” эсвэл “...хоригдлыг сайн дурын үндсэн дээр хамруулна”[3] гэхчлэн заасан нь хоригдолд холбогдох сургалтыг хорих байгууллага явуулж ч болох явуулахгүй ч байж болох мэт болсон нь судалгааны явцад харагдаж байна.

Хорих байгууллага хорих ял эдлэгсдийг мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамруулан энэ ажлыг стандартад нийцүүлэн зохион байгуулж чадвал нэг талаар өөрийн орны бүтээн байгуулалт, бүтээгдэхүүний чанарыг

[1]А. Лхагва, Д. Даваа-Очир. МУ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. УБ. 2011.

[2] А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж. УБ., 2013, 11-42 дахь талд нийтлэгдсэн.

[3]“Төрийн мэдээлэл” эмхэтгэл УБ., 2017

-Хорих анги өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно.

-Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хоригдлыг сайн дурийн үндсэн дээр хамруулна.

дээшлүүлэх, нөгөө талаар хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх ажлыг эрчимжүүлэн хорихоос суллагдагсдыг ажлын байраар хангах боломж бүрдүүлснээр тэднийг нийгэмд өөрийн байр суурийг олж амьдрахад сайн нөлөө үзүүлэх талтай, ба гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх нь практик байдлаас харагдаж байна.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2019 оны 2-р сарын байдлаар гаргасан тайландаа дурдахдаа, нийт 2883 хоригдол ял эдэлж байгаагаас бичиг үсэг үл мэдэгч-203, боловсролгүй-298, бага боловсролтой-427, бүрэн бус дунд-841, бүрэн дунд-917 хоригдол байгаа нь бүх шатны боловсролын хөтөлбөр боловсруулах зайлшгүй шаардлага урган гарч байна.[4]

Хоригдлуудын ажлын байрыг нэмэгдүүлж, ял эдлэх хугацааг нь үр ашигтай өнгөрүүлэн, суллагдсаныхаа дараа эзэмшсэн мэргэжлээрээ хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх, бие хүнийг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой.

Ял эдлэгсдийн боловсролын талаар олон улсын баримт бичиг болох “Хоригдолтой харилцах наад захын жишиг дүрмийн 77 дугаар зүйлд хоригдлуудад боловсрол эзэмшүүлэх явдлыг тухайн орны боловсролын системтэй холбож, суллагдсаны дараа ч гэсэн тэд боловсролоо дээшлүүлэх боломжтой байхаар зохион байгуулна. Гишүүн орнууд нь боловсролын бодлогыг боловсруулахдаа дараах зарчмыг баримталвал зохино гэжээ. Үүнд:

- ✓ Хоригдлын нийгэм, эдийн засаг, соёлын суурийг анхааран шоронгийн боловсрол хүнийг бүх талаар нь хөгжүүлэх зорилготой байна.
- ✓ Бүх хоригдол бичиг үсэг сурах, суурь боловсрол, мэргэжлийн сургалт, бүтээх сургалт, шашны болон соёлын арга хэмжээ биеийн тамирын боловсрол, нийгмийн боловсрол эзэмших, номын санд суух эрхтэй.
- ✓ Шоронгийн дэглэмийн салшгүй хэсэг нь боловсрол байна. Батлагдсан албан ёсны боловсролын хөтөлбөрт оролцож байгаа хоригдлыг дэмжвэл зохино.
- ✓ Тусгай мэргэжлийн боловсролыг хувь хүнийг хөгжүүлэх чиглэлээр олгох ба хөдөлмөрийн зах зээлийн хандлагыг нарийн мэдэрвэл зохино.

[4]ШШГЕГ-ын 2018 оны 02-дугаар сарын тайлан.

- ✓ Бүтээлч болон соёлын арга хэмжээнд онцгой анхаарч өөрсдийгөө хөгжүүлэх авьяасаа илэрхийлэх бололцоог тэдэнд олговол зохино.
- ✓ Боломжтой бол хоригдлуудад шоронгийн гадна боловсрол эзэмшихийг зөвшөөрч болно.
- ✓ Шоронд олгох боловсролын ажилд орон нутгийн байгууллага аль болохоор оролцох ёстой.
- ✓ Хоригдлууд зохих боловсрол авахад шаардагдах хөрөнгө төсөв, тоног хэрэгсэл, багшлах боловсон хүчинтэй байвал зохино.[5]

Эндээс үзэхэд Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Байгууллага нь дээрх зарчмуудыг баримтлан ажиллаж байгаа хэдий ч зарим нэг заалтыг хэрэгжүүлэхгүй байна. Тухайлбал: хоригдлуудад шоронгийн гадна боловсрол эзэмших, орон нутгийн байгууллагыг аль болохоор татан оролцуулах, боловсрол олгоход шаардагдах хөрөнгө төсөв,тоног хэрэгсэл, багшлах боловсон хүчинтэй байх зэрэг нь хангалттай түвшинд хүрээгүй байна гэж үзлээ.

Хөгжлийн санаачлага, Бодлого судлалын төв, MBS Хууль зүйн Фирмээс 2013 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Үйлчилгээний ажилд хяналт-шинжилгээ, үнэлгээ /мониторинг/ явуулсан тухай судалгааны тайланд хорих ял эдлэгсдэд мэргэжил эзэмшүүлэх талаар дурьдсан байна.

Хорих ангиудад харьцангуй сайн зохион байгуулдаг нэг арга хэмжээ бол мэргэжил олгох сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг болсон байна. Үүнд барилгын чиглэлийн, мужаан, дархан, гар урлал, оёдол, талх, нарийн боов, тогооч гэх мэт нэлээд олон төрлийн сургалтуудыг хорих ангийн хэмжээнд мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв гэсэн тусдаа статустай байгууллага байгуулж, тэндээс нэгдсэн төлөвлөгөөний дагуу хорих ангиудад сургалт явуулдаг болсон нь ихээхэн үр дүнтэй арга хэмжээ болсон байна.

Судалгааны хүрээнд нийт 117 хоригдлуудын дунд ямар төрлийн сургалт илүү хэрэгцээтэй байгааг тандах асуулт асуусан ба доорх байдлаар хариулсан байна.[6] Үүнд:

- ✓ Мэргэжил олгох сургалт 67 буюу 53,6%

[5]Хүний эрх ба хорих байгууллага. УБ., 2000, 67-68 дахь тал

[6] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний мониторнг тайлан. УБ., 2013он.

- ✓ Хэлний сургалт 53 буюу 42,4%
- ✓ Амьдрах ухааны сургалт 17 буюу 13,6%
- ✓ Бизнес эрхлэх, зах зээлийн сургалт 17 буюу 13,6%
- ✓ Хууль эрх зүйн сургалт 19 буюу 15,2%
- ✓ Хүмүүжил төлөвшлийн сургалт 4 буюу 2,2%

Дээрх судалгаанаас харахад хоригдлууд мэргэжил эзэмших сургалтад суралцах хүсэлтэй байгаа нь илт байна. Үүний тулд манай байгууллага хоригдолд олгох урамшуулал, тэтгэлэг, суралцах нөхцөл журмыг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. Монгол улсын хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн тушаалаар “Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр”-ийг баталжээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд зайлшгүй шийдвэрлэх асуудлын нэгдүгээрт, ял эдлэгсдэд хүмүүжлийн нөлөө үзүүлэн төлөвшүүлэх, хоёрдугаарт, тэдэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэн, хөдөлмөрлөх дадал олгох, гуравдугаарт, тэднийг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдтэй ойртуулах,эвлэрүүлэн зуучлах, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах, ялтныг суллагдан гарахад бэлтгэх зэрэг ажлуудыг зохион байгуулах шаардлагтай гэж үзжээ. Тус хөтөлбөрийн зорилтын нэгд нь хоригдолд мэргэжил эзэмшүүлэх чиглэлээр

Барилгын болон жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт ажиллах чадвартай мэргэжилтэй ажилтан бэлтгэх “Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв”-ийг байгуулж үйл ажиллагааг нь тогтмолжуулах, хоригдлын ажлын байрыг нэмэгдүүлэх, мэргэжил олгон чадваржуулах, ялтны ял эдлэх хугацааг үр ашигтай байлгаж, тэднийг суллагдсаны дараа эзэмшсэн мэргэжлээрээ нийгэмд бие даан амьдрах боломжийг бүрдүүлэх зорилготой.

Судалгаанд нийт 72 хүн оролцсоноос 32 хүн буюу 44,5% нь 18-30 насны хүмүүс, 40 хүн буюу 55,6% нь 31-ээс дээш насны хүмүүс байна.

Судалгаанд хамрагдсан хоригдлуудыг боловсролын түвшингээр авч үзвэл 7 хүн буюу 9,7% бага боловсролтой, 11 хүн буюу 15,3% бүрэн бус дунд боловсролтой, 40 хүн буюу 55,6% бүрэн дунд боловсролтой, 3 хүн буюу 4,2% нь тусгай дунд боловсролтой, 11 хүн буюу 15,3% нь дээд боловсролтой байна.

Хорих ангиас зохиогдож байгаа ямар нэг сургалтанд 66 хүн буюу 91,7% нь хамрагдсан бол үлдсэн 6 хүн буюу 8,3% нь огт хамрагдаж байгаагүй байна.

- ✓ Та хорих ангиас явуулж буй сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа хүртээмжтэй байдаг гэж бодож байна уу? Гэсэн асуултанд 62 хүн буюу 86,1% нь тийм 10 хүн буюу 13,9% нь үгүй гэж хариулсан.
- ✓ Танд мэргэжил дээшлүүлэх хүсэл, сонирхол бий юу? Гэсэн асуултанд 67 хүн буюу 93,1% нь тийм 5 хүн буюу 6,9% нь үгүй гэж хариулсан.
- ✓ Таны бодлоор хорих ангид явагдаж буй сургалтыг зохион байгуулах орчин бүрдсэн үү? Гэсэн асуултанд 52 хүн буюу 72,2% нь тийм 20 хүн буюу 27,8% нь үгүй гэж хариулсан.
- ✓ Та цаашид хорих ангиас ямар сургалт явуулвал хамрагдах вэ? Гэсэн асуултанд мужаан, гагнуур, тогооч, мэргэжил дээшлүүлэх, нийгэмшүүлэх, жолооны сургалтанд түлхүү амрагдах хүсэлтэй байсан.
- ✓ Та Монгол улсын үндсэн хуульд заасан сурч боловсрох эрхээ эдэлж чадаж байна уу? Гэсэн асуултанд 61 хүн буюу 84,7% нь тийм 11 хүн буюу 15,3% нь үгүй гэж хариулсан.

2. Хоригдолын дунд явуулж байгаа сургалтын талаарх манай орны болон гадаад улс, орнуудын эрх зүйн зохицуулалтын харьцуулалт

Монгол Улсын их хурлаас 2015 онд баталж, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлд Эрүүгийн хариуцлагын зорилгыг “гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино” заасан билээ.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэн батлагдсантай холбоотойгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль шинэчлэгдэн батлагдаж, мөн дээрх өдрөөс мөрдөж эхэлсэн бөгөөд өмнөх хуулиудтай харьцуулахад нилээд өөрчлөлт оржээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 266 дугаар зүйлд “Хорих ял эдлүүлэх албаны чиг үүрэг”-ийг тодорхойлж, 266.1.5-д “хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, дахин нийгэмшүүлэх, мэргэжлийн

боловсрол, сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох чиглэлээр санал боловсруулах” үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна.

Харин Хорих ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй хорих ангийн үүргийг тус хуулийн 267 дугаар зүйлд тусгаж, 267.2.3-д “хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх”; 267.2.4-д “хоригдлыг хөдөлмөрлүүлэх, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд дадлага олгох”; 267.2.5-д “хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнийг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох” гэжээ. Үүнээс харахад нийгэмшүүлэх ажлын нэг хэлбэр сургалт бөгөөд үүнийг хорих байгууллагын чиг үүрэг болгон хэрэгжүүлж байгаа нь харагдаж байна. Өмнөх буюу 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиас ялгаатай нэг онцлог зохицуулалт нь хүмүүжүүлэх ажил гэсэн томьёолллыг өөрчилж, нийгэмшүүлэх ажил гэсэн ойлголтоор 218 дугаар зүйлд тусгасан нь цаг үеэ олсон гэж дүгнэж болно.

Оросын Холбооны Улс

Оросын Холбооны Улс нь эрх зүйн тогтолцооны хувьд Монгол Улстай нэг бүлд хамаарахаас гадна 1990 оныг хүртэл хугацаанд түүхэн учир шалтгааны улмаас эрх зүйн адил загвартай байсан гэж үзэж болох талтай. Тус улсын Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн 14-р бүлэгт Хорих ял эдэлж буй ялтнуудыг мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтад хамруулах талаар зохицуулалтыг заасан байна.

1. Мэргэжилгүй хоригдлуудад анхан шатны мэргэжлийн боловсрол, мэргэжлийн бэлтгэл олгох ажлыг засан хүмүүжүүлэх газар зохион байгуулна. Мэргэжил эзэмшсэн хоригдлууд засан хүмүүжүүлэх байранд болон суллагдсаныхаа дараа ч тэндээ ажиллаж болно.
2. Тахир дутуугийн 1,2 дугаар группт байдаг хоригдлууд 60-аас дээш насны эрэгтэй мөн 55-аас дээш насны эмэгтэй хоригдлуудыг өөрсдийнх нь хүсэлтээр холбогдох мэргэжлийн сургалтад хамрагдуулж болно.
3. Хоригдлуудыг анхан шатны мэргэжлийн, боловсролын сургалтад хамруулахдаа тэдний хүмүүжиж буй зэргийг харгалзан үзнэ.
4. Анхан шатны мэргэжлийн боловсрол олгох мэргэлийн сургалт зохион байгуулах ажлыг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас тогтоосон журмын дагуу явуулна. Засан хүмүүжүүлэх байгууллага нь

хоригдлуудын дээд мэргэжлийн боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

5. Бүх насаараа хоригдож буй ялтнууд шууд үйлдвэр дээр мэргэжил эзэмшинэ гэж хуульчилсан.[7]

Бүгэд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын хорих байгууллагуудыг Хууль зүйн яам мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилладаг. Хорихын дарга хоригдлын ур чадварыг сайжруулах, дээшлүүлэх үүднээс хөдөлмөрийн мэргэжлийн сургуулийг байгуулж болдог. Хорихын дарга хоригдлын мэргэжлийн сургуульд шаардлагатай гэж үзвэл гадны байгууллага, үйлдвэрт мэргэжлийн сургалтыг хийлгэж болдог байна. Мэргэжлийн сургуульд холбогдох шаардлагтай зүйлийг хууль зүйн яам шийдвэрлэдэг байна.

Хорих засан хүмүүжүүлэх байгууллага нь гэмт хэрэгтнийг ял эдэлж хугацаанд нь шаардлагатай мэдлэг чадварыг эзэмшүүлэх болон эргээд нийгэмших үйл явцад нь дэмжлэг үзүүлнэ.

Хэрэв гэмт хэрэгтэн “Боловсролын хууль-д заасны дагуу албан ёсны боловсрол эзэмшээгүй бол ял эдэлж байх хугацаанд түүний нас, хүсэл, мэдлэг чадварын түвшин болон бусад зүйлсийг судлан үзэж тохирсон сургалтад хамруулна.

Боловсролын хуульд заасны дагуу гэмт хэрэгтнийг боловсрол эзэмшүүлэхээр хорих газраас гадуур сургалтад хамруулж болно. Сургалтын үйл явцад хорих газраас гадуур сургалтад хамруулахыг Хууль зүйн яамны захирамжаар зохицуулна. Хорих, засан хүмүүжүүлэх газар нь хүмүүжигчдэд мэргэжлийн баримжаа олгох зөвлөгөө, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх ба ухааруулан засан хүмүүжүүлэх тусгайлсан хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

Ухааруулан засан хүмүүжүүлэх хөтөлбөр нь төрөл, агуулгын хувьд хууль зүйн яамнаас гаргасан захирамж, журамд зохицуулагдана.

Гэмт хэрэгтнийг эргээд нийгэмд хөдөлмөрлөх хүсэл, зоригийг бий болгоход тохирсон технологийг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

Хорих, засан хүмүүжүүлэх газраас гэмт этгээдийн нас, ял эдлэх хугацаа, эрүүл мэндийн байдал, технологи, хувь хүний байдал, сонирхол,

[7] Уголовно-исполнительный кодекс Российкой Федаераций. Постатейные материалы 2005г. Стр 579-580

дадлага, туршлага, ирээдүйн төлөвлөлт болон бусад зүйлсийг засан хүмүүжүүлэх хөдөлмөр эрхлүүлэхэд харгалзан үзнэ. Гэмт хэрэгтэн ажиллах үүрэгтэй. Хорих, засан хүмүүжүүлэх газар нь гэмт хэрэгтний өргөдлийн дагуу хөдөлмөрлүүлдэг байна.

Хорих засан хүмүүжүүлэх газраас гадуур компани, ажлын байранд техник технологи эзэмшүүлэх, эргэн нийгэмшүүлэх зорилгоор ажиллуулж болно. Гэмт хэрэгтнийг хорих, засан хүмүүжүүлэх газраас гадуур ажиллуулах шаардлагатай үед ажиллах хүний сонголтын шалгуур нь хууль зүйн яамны захирамжаар зохицуулагдана.[8]

Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх, техник технологи эзэмшүүлэх үүднээс мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулж болно. Шаардлагатай тохиолдолд гэмт хэрэгтний мэргэжлийн сургалтыг хорих газраас гадуур мэргэжил олгох байгууллага дээр зохион байгуулж болно.

Мэргэжлийн сургалтад хамруулах хүний сонгон шалгаруулалтыг хууль зүйн яамны захирамжаар зохицуулна.

Бүгд Найрамдах Беларус Улс

Беларус Улсын судалгааны төвийн мэдээллээс үзвэл 2012 оны эцэст 100,000 хүн тутамд хоригдлын тоогоор 438 буюу Европын олон орнуудын индексээс хэт өндөр үзүүлэлт "...2010-2011 оны мэдээгээр нийт хоригдлуудын 60-аас дээш хувь нь урьд өмнө нь ял авч байсан. дээрэм хийсэн хэрэгт ял шийтгүүлсэн нийт хүмүүсийн 74 орчим хувь нь дахин эрүүгийн хэрэгт холбогдсон, бусдын бие махбодид санаатайгаар гэмтэл учруулсан хэргээр ял шийтгүүлсэн хүмүүсийн 49 хувь нь урьд өмнө ял шийтгэгдсэн, мөн хүчингийн хэрэгт шийтгэгдсэн хүмүүсийн 59 хувь, танхайрсан хэргээр яллагдагчдын 42 хувь нь урьд өмнө ял эдэлж байсан (Красиков, Пастушения, 2012: 14) байна.

Беларус улсад мөрдөгдөж буй Эрүүгийн хууль, Боловсролын тухай хуулинд зөвхөн ял, шийтгэлийг хэрэгжүүлэхээс гадна хоригдлуудыг нийгэмшүүлэхэд чиглэсэн боловсролын олон арга хэмжээг авах эрх зүйн зохицуулалт байдаг бөгөөд хоригдлыг анхан шатны, дунд, мэргэжлийн боловсролыг олгох талаар дурдсан байна.

[8]Д. Насанбат, А. Цэнгэл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх. Эрх зүй. УБ. 2014. 155-159 тал.

2015 оны байдлаар Беларус улсын хорих байгууллагын системд анхан болон дунд шатны боловсрол эзэмшүүлэх зорилго бүхий насанд хүрэгчдийн 5 сургууль ажилладгаас гадна гагнуурчин, тракторчин, токарьчин, тээрэмчин гэх мэт 28 мэргэжлийн чиглэлээр 21 коллеж үйл ажиллагаа явуулдаг байна. Сургалтын үйл ажиллагаанд Боловсролын яамны харьяа агентлагууд хяналт тавин ажилладаг бөгөөд сургалт дууссаны дараа стандарт бүхий боловсролын диплом олгогддог байна. Түүнээс гадна, мэргэжлийн боловсрол олгох сургалт нь ажлын байраар хангах, практик дадлага хийх хэлбэрээр явагддаг бөгөөд энэ нь эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаанд эерэг нөлөө үзүүлж, хувь хүний хувьд нийгэмших боломжийг олгодог байна.

Финланд улс:

Нийт таван сая хүн амтай Финлянд улсад 3500 орчим хоригдол байдаг. Хоригдлууд 20 хаалттай, 15 нээлттэй хорих байгууллагад ял эдэлдэг бөгөөд жил бүр ойролцоогоор 9000 зөрчлийг шийдвэрлэдэг байна. Хорих ял эдэлж буй ихэнх хоригдлууд 25-аас 39 хүртэлх насны залуучууд бөгөөд тэдний дундаж нас нь 33 орчим байна. Мөн хорих ангийн хүн амын 3.5 хувь нь эмэгтэйчүүд байдаг. Боловсролын байдлаар нь авч үзвэл залуу хоригдлуудын, өөрөөр хэлбэл 15-аас 20 насны хүмүүсийн гуравны нэг нь суурь боловсролгүй, 30 хувь нь (ихэвчлэн богино) мэргэжлийн сургалтанд хамрагдсан, 29 хувь нь мэргэжлийн боловсролын гэрчилгээтэй, 1 хувь нь дээд боловсролтой байжээ. Энэхүү нөхцөл байдлыг харгалзан тус услын хорих байгууллагын системд боловсролын ач холбогдлыг нэмэгдүүлж, эхний ээлжилд дөрвөн хоригдол тутмын нэгийг боловсрол эзэмшүүлэх зорилт тавин ажиллаж, мэргэжлийн боловсрол олгох ажилд анхааржээ. Хорих ангид ял эдлэх хугацаандаа мэргэжил эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах тэдний хүсэл, сонирхолд тулгуурладаг бөгөөд хоригдлуудын гуравны нэгээс илүү нь (37 хувь) шоронд байхдаа суралцахыг хүсдэг байна.

Финланд Улсын хорих ангиудад суурь боловсролыг нэн тэргүүнд олгохыг эрмэлздэг бөгөөд энэхүү сургалт албан ёсны боловсролын системээр зохион байгуулагддаг онцлогтой.

Өөрөөр хэлбэл, хорих ангид суурь боловсрол олгох үндсэн зарчим бол гадны буюу энгийн боловсролын байгууллагууд сургалтыг зохион байгуулдаг явдал юм. Тиймээс шоронд олгож буй суурь боловсрол нь ерөнхий боловсролын тогтолцоотой ижил төстэй заах арга, хичээлийн

хэрэглэгдэхүүн, материал ашиглагдахаас гадна боловсрол эзэмшсэн гэрчилгээ нь хорих ангид гэдгийг огт дурддаггүй юм.

Тус улсын насанд хүрэгчдэд зориулсан орон нутгийн ахлах сургуулийн сургуулиас долоон хорих ангид нэг бүлэгт 4-12 суралцагч, дунджаар 8 орчим суралцагчтайгаар сургалт явуулдаг байна. Харин бага ангийн буюу бичиг үсгийн боловсрол (унших, бичих, тоолох) ологох бүлгүүдэд нэг багш дээдтал нь 5 хоригдолд хичээл заах норматив тогтоожээ. Харин төгсөлтийн шалгалтыг тухайн улсын албан ёсны боловсруулагаас ирж авах ба бусад боловсролын байгууллагуудын мэдлэг чадвартай харьцуулж, үнэлэлт өгдөг бөгөөд сургалтыг бүрэн дүүргээгүй хоригдлыг суллагдсаны дараа ижил сургуульд үргэлжлүүлэн суралцуулдаг.

Дүгнэлт

Хоригдолд эзэмшүүлэх сургалтыг ялгамжтай заасан хууль, эрх зүйн үндэсллүүд болон онол, түүхэн эх сурвалж, олон улсын жишгийг судлан үзэж, гурван ангийн хоригдлуудаас анкетын аргаар авсан судлагааг нэгтгэн шинэжлэсний үндсэнд доорхи дүгнэлтийг дэвшүүлж байна.

Хоригдолд эзэмшүүлэх сургалтыг ялгамжтай заасан нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол улсын олон улсын гэрээг зөрчиж байна.

Хоригдлуудын дунд явуулж буй сургалтыг ялгамжтай заасан нь хууль зүйн үндэслэлгүй байна. Сурах эрхийг хязгаарласан үндэслэлүүдийн эрүүгийн эрх зүйн хязгаарлалтаас бусад үндэслэл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээнд тусгагдсан хүний эрхийг хязгаарлах үндэслэлүүдэд харшлахгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хоригдолд мэргэжил эзэмшүүлэх, тэднийг нийгэмшүүлэх зорилгоор мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулан ажиллуулж байгаа нь ололттой тал боловч тус төвийн хууль эрх зүйн орчин, хичээллэх нөхцлийг улсын хэмжээний мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн байдалтай харьцуулахад тэдний хэмжээнд хүрээгүй байна.

Гадаадын зарим орнууд мэргэжил олгох сургалт зохион байгуулахдаа хөдөлмөрийн зах зээл дээр байгаа ажил, мэргэжлийг анхаарч тэтгэлэг олгох, сургалтыг хөдөлмөр эрхэлсэнтэй адилтган үзэж байгаа байдал нь Монгол улсын тухайд туршлага болох талтай гэж үзэж байна.

Судалгааныхаа ажилд тулгуурлан дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- ✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харъяа төрийн өмчит мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн боловсролын системд ажиллаж байгаа мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдтэй гэрээ байгуулан ажиллах. Энэ саналыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газрын тогтоол гаргуулах.
- ✓ Хорих ангийн дотоод журмын 9.2-д сургалтыг хоригдлын үйлдсэн гэмт хэрэг насны онцлог хувийн байдал, хорих ангийн дэглэм зэрэглэлээс хамааран ялгамжтай явуулна гэсэн заалтыг хүчингүйд тооцож нийтэд нь сургалтанд хамруулах талаар тусгах.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

Хууль, эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
- БНМАУ-ын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай хууль 1931
- Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль 1993
- Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль 1996
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002
- Монгол Улын Боловсролын тухай хууль 2002
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017

Ном, гарын авлага, сурах бичиг

- Л. Чүлтэмсүрэн. Засан хүмүүжүүлэх байгууллагын товч түүх. УБ. 1979 он
- С. Нарангэрэл. БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүйн асуудал. УБ. 1985
- А. Лхагва. Засан хүмүүжүүлэх байгууллагад хорих ял эдлэгсдийн хөдөлмөр зохион байгуулалт, түүний эрхийн асуудал. УБ. 1989.
- А. Лхагва. С. Жанцан. Монгол Улсын Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй. УБ. 1996.
- Б.Дашзэвэг. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ. 2004.

- Р. Оюун бадам, Д. Бадам. Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалт. УБ. 2005.
- Х. Пүрэвсүрэн. Хорих ял эдлэгсдийн эрхийн байдал. УБ. 2010
- А. Лхагва, Д. Даваа-Очир. МУ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. УБ. 2011.
- А. Лхагва. МУ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж. УБ. 2013
- Д. Насанбат, А. Цэнгэл. Шүүхийн шийдвэр гйүцэтгэх эрх зүй. УБ. 2014.

Бусад материалууд.

- Хорих ангийн дотоод журам. 2017
- ШШГЕГ-ын 2018 оны 02-дугаар сарын тайлан
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний мониторинг тайлан. 2013
- www.legalinfo.mn

МОНГОЛ УЛСЫН ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ГЭМТ ЯВДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Ч.БАТБОЛД
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн судлаач-докторант, хошууч,

Товч агуулга: сэдвийн хүрээнд Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үйлдэгдэж буй гэмт явдал буюу олон улсын хэллэгээр “Пенитенциар” гэмт явдалд дүн шинжилгээ хийн, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаарх өөрийн санал, дүгнэлтийг гаргасан болно.

Түлхүүр үг: хорих ял эдлүүлэх ажиллагаа, чиг үүрэг, пенитенциар гэмт явдал, үзлэг, нэгжлэг, хориотой эд зүйл, хоригдлын үйлдсэн зөрчил, сахилгын шийтгэл.

Abstract

Key words

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь эрүүгийн ялын бодлого, зорилгыг хангахад чиглэн тухайн улс орны хөгжлийн шат дахь нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг хангах, хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг хэрэгжүүлэхэд төрөөс баримталж буй чиглэл бөгөөд төрийн зүгээс эрүүгийн ялын бодлогоо хариуцлагын оновчтой төрөл, тогтолцоог бий болгон, оногдуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох, түүгээр дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зэрэг арга хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлж байдаг[1].

Хорих байгууллага нь хорих ял эдэлж буй хоригдол, цагдан хоригдож буй хоригдогсдын дотроос гэмт хэрэг үйлдэх, нийгэм, ард иргэдийг гэмт халдлагад өртөхөөс хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага юм.

[1] Б.Алтангэрэл. “Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үйлдэгдэж буй гэмт хэрэг, түүнийг судлах нь” эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл. 2014 он.

Хорих ял эдлүүлэх явцад үйлдэгдэж буй гэмт явдал буюу олон улсын нэр томьёололоор “Пенитенциар” гэмт явдал нь бөгөөд хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад алба хаагч, хоригдол, хоригдогсдын зүгээс холбогдох хууль тогтоомж, хорих ангийн дотоод журам зөрчсөн гэмт хэргүүдийн цогц гэж үзэж болох юм.

Криминологийн толь бичгүүдэд “пенитенциар [2] гэмт явдал” гэж “хорих газрын (шоронгийн), өөрөөр хэлбэл үйлдэгдэх газраар тодорхойлогдож байгаа гэмт явдал” гэжээ.

Толь бичиг зохиогчдын үзэж байгаагаар энэ гэмт явдлын онцлог нь пенитенциар тогтолцооны байгууллагын өвөрмөц нөхцөл, хоригдлын нийгмийн онцгой орчноор тодорхойлогдож байгаа юм[3]. Энэхүү гэмт явдал нь хоёр төрлийн субъекттэй. Үүнд:

1. Хорих газар ял эдэлж байгаа хоригдол;

2. Эрүүгийн ял эдлүүлэх тогтолцооны байгууллага, хорих ангийн алба хаагч зэрэг субъектийг авч үзнэ.

Доктор (Ph.D) Ц.Очгэрэл бүтээлдээ хорих байгууллагын аюулгүй байдлын төрлийг Монгол Улсын дотоод аюулгүй байдлыг хангахад гүйцэтгэх оролцооны шинжтэй уялдуулан дараах байдлаар ангилжээ. Үүнд:

1. Хорих байгууллагын үйл ажиллагааны аюулгүй байдал;

2. Ажилтан алба хаагчийн аюулгүй байдал.

3. Хоригдогч, ялтан бусад хүмүүсийн аюулгүй байдал;

-Бусад хүмүүс гэдэгт хоригдогч ялтны зүгээс үйлдэж болзошгүй гэмт халдлагад өртөж болзошгүй иргэд, нийгмийн бусад төлөөлөл, хорих ангийн бүс, байрлалд түр хугацаагаар нэвтэрч байгаа тодорхой ажил гүйцэтгэж байгаа албан тушаалтан, иргэдийг хамруулж ойлгоно.

4. Хорих анги, цагдан хорих, баривчлах байр, байгууламж, техник хэрэгслийн аюулгүй байдал[4].

Монгол Улсад сүүлийн 50 жилд үйлдэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтэд судалгаа хийж үзэхэд 1968 онд-3436, 1978 онд-4251, 1988 онд-6614, 1998 онд-22737, 2008 онд-20704, 2018 онд-36620 гэмт хэрэг улсын

[2] “Пенитенциар”гэсэн нэр томъёо нь латины poenitentia-гэмээ наманчлах гэсэн үгнээс гаралтай; пенитенциар нь (XIXзууны дунд үе) шоронгийн хэв маяг бүхий засан хүмүүжүүлэх байгууллагад хамаарах бөгөөд, ийм байгууллагыг анх засан хүмүүжүүлэх асуудалтай холбоотойгоор байгуулагджээ.

[3] См.: Российская криминологическая энциклопедия/ Под общ.ред.А.И.Долговой. М., 2000. С.596.

[4] Ц.Очгэрэл. “Хорих байгууллагын аюулгүй байдал”. УБ., 2017 он. 91 дэх тал.

хэмжээнд бүртгэгдсэн судалгаа байна. Дээрх тоо баримтаас харахад сүүлийн 50 жил гэмт хэрэг 10 дахин өссөн үзүүлэлттэй байна.[5]

Судалгаанаас үзэхэд Монгол Улсад 2007-2010 онд нийт **31393** хүн ял шийтгүүлснээс **23193** хүнд хорих ял оногдуулсан [6] нь нийт ял шийтгүүлэгчдийн 60-аас дээш хувийг хорих ял шийтгүүлэгчид эзэлж байсан байна.

Харин хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад 2003-2020 оны хооронд хоригдлоос 441 гэмт хэрэг үйлдэгдсэн [7] нь хорих ял эдлүүлэх явцад үйлдэгдэж байгаа гэмт хэргийн талаар шинжлэх ухааны үндсэн дээр судлах, урьдчилан сэргийлэх тусгай арга зүйг боловсруулах шаардлага урган гарч байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хэмжээнд төвлөрсөн хорих анги 21 үүнээс нээлттэй хорих анги 7, хаалттай хорих анги 5, нээлттэй, хаалттай хорих анги 5, өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага 1, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 2, эмэгтэйчүүдийн хорих анги 1, баривчлах төв, байр тус бүр 1, Нийслэлд цагдан хорих төв 1, орон нутагт 25 цагдан хорих байр үйл ажиллагаа явуулж, 2020 оны жилийн эцсийн байдлаар нээлттэй хорих ангид **3126**, хаалттай хорих ангид **1336**, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан **1132** нийт **5594** хоригдол, хоригдогчид [8] харуул хамгаалалтын хяналтыг тасралтгүй тавин ажилласан байна.

Хорих ял эдлэгсдийг үйлдсэн гэмт хэргээр ангилж үзвэл 1134 /25.2 хувь/ нь хүнийг алах /ЭХТА-н 10,1/, 775 /16.8 хувь/ нь хүчиндэх /ЭХТА-н 12.1/, 256 /5.7 хувь/ нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах /ЭХТА-н 20.7/, 1229 /27.3 хувь/ хулгайлах гэмт хэрэг үйлдсэн бол үүнээс 221 буюу 4.9 хувь нь мал хулгайлах гэмт хэрэг үйлджээ. ЭХТА-д заасан бусад төрлийн гэмт хэрэгт ял эдлэгсэд 25.8 хувийг эзэлж байна[9].

Хуульд заасан гэмт хэргүүд дотроос хүнийг алах, хүний эрүүл мэндэд хохирол санаатайгаар учруулах, хулгайлах, дээрэмдэх, залилах, авто

[5] Б.Алтангэрэл, Ч.Мөнх-Эрдэнэ нар. Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ 2003-2018.УБ., 2019 он. 30 дахь тал
[6] Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт. УБ., 2013. 145 дахь тал
[7] Б.Алтангэрэл, Ч.Мөнх-Эрдэнэ нар. Дурдсан зохиол 2019 он. 92 дахь тал
[8] Хорих ял эдлүүлэх албаны 2020 оны жилийн эцсийн тайлан.
[9] Хорих ял эдлүүлэх албаны 2020 оны жилийн эцсийн тайлан.

тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих зэрэг 7-8 төрлийн гэмт хэрэгт хорих ял шийтгэгдсэн хоригдлууд зонхилон ял эдэлж байгаа бол сүүлийн жилүүдэд буюу 2016 оноос хойш шинэ төрлийн гэмт хэрэг болох мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг болон авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгэгдсэн хоригдлын тоо эрс нэмэгдэх хандлагатай байна.


Зөвхөн 2006 онд хар тамхитай холбоотой 6 гэмт хэрэгт 33 холбогдогч шалгагдан шийтгэгдэж байсан бол 2018 онд 197 гэмт хэрэгт 402 хобогдогч шалгагдсан буюу хэргийн тоо 32 дахин, холбогдогчийн тоо 12 дахин өсчээ.

Хоригдлын аюулгүй байдлыг хангах, өөрийн болон бусдын бие эрхтэнд гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны жилийн эцсийн байдлаар хоригдол, хоригдогчийн бие, эд зүйл, хорих байр, хамгаалалтын бүс, түүнчлэн хоригдол хөдөлмөр эрхэлж байгаа хэсэг салбар, тээврийн хэрэгсэл, хорих байгууллагад нэвтэрч буй этгээдийн бие, эд зүйлд төлөвлөгөөт үзлэг, нэгжлэг **5326,** төлөвлөгөөт бус үзлэг, нэгжлэг **6941** удаа хийж, хөдөлгөөнт утас 20 ширхэг, бэлэн мөнгө 106150 төгрөг, зэвсгийн чанартай ашиглаж болохуйц эд зүйл 432 ширхэг, бусад эд зүйл /*тамхи, асаагуур, эмчийн зөвшөөрөлгүй эм, садар самуун сурталчилсан сонин, сэтгүүл гэх мэт*/ 4521 ширхэг, нийт **6** нэр төрлийн **4973** хориотой эд зүйлийг хураан авч зохих журмын дагуу шийдвэрлэжээ[10].

Хоригдлын дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, хоригдлоос нийгэм, иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх үүднээс хорих ангийн дотоод журам зөрчсөн **25**, хоорондоо маргалдаж, бусдыг доромжилсон **15**1, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлага биелүүлээгүй, эсэргүүцсэн **64**, хөдөлгөөнт утас ашигласан **20**, хориглосон эд зүйл хадгалсан **24** зөрчил гаргасан хоригдол, хоригдогч нарт хорих анги, байгууллагын даргын тушаалаар түр болон удаан хугацааны уулзалтын эрх хасах **22**, утсаар ярих эрх хасах **55**, сахилгын байранд хорих **115**, шагналын хоног хасах **51** сахилгын шийтгэлийг тус тус оногдуулсан байна[11].

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд сүүлийн 5 жилд нийт 19 гэмт хэрэг гарсан ба үүнийг өнгөөр нь авч үзвэл оргох 12 буюу 63.2 хувь, хүний биед гэмтэл учруулсан 6 буюу 31.6 хувь, бусад гэмт хэрэг 1 буюу 5.2 хувийг тус тус эзэлж байна.

[10] Хорих ял эдлүүлэх албаны 2020 оны жилийн эцсийн тайлан.
[11] Хорих ял эдлүүлэх албаны 2020 оны жилийн эцсийн тайлан.



Сүүлийн 5 жилд нийт 1733 зөрчил гарсныг өнгөөр нь авч үзвэл гар утас ашигласан 531 буюу 30.7 хувь, архи уусан 52 буюу 3 хувь, албан хаагчийн хууль ёсны шаардлага эсэргүүцсэн, хорих ангийн дотоод журам зөрчсөн 466 буюу 26.9 хувь, бусдыг дарамталсан, хоригдол хоорондоо маргасан зодолдсон 566 буюу 32.6 хувь, хориотой тоглоом тоглосон, хориотой эд зүйл нэвтрүүлсэн, хадгалсан 118 буюу 6.8 хувийг тус тус эзэлж байна.



2020 онд гарсан зөрчлийг 2019 онд гарсан зөрчилтэй харьцуулахад нийт зөрчил 17-оор буюу 5,9 хувиар өссөн дүнтэй байгаа нь 2019 онд хоригдож байсан хоригдол, хоригдогсдын тоо 408-аар буюу 7,8 хувиар өссөнтэй холбоотой байна.

Хорих байгууллагад үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн тоо хэдийгээр буурч байгаа боловч таслан зогсоогдохгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Хорих ангид ял эдэлж буй хоригдлоос байгууллагын дотоод журам зөрчих, гэмт хэрэг зөрчих зэрэг ноцтой үйлдэл гаргадаг байна. Хоригдлын дундаас дотоод дэг журам зөрчих гэмт хэрэг үйлдэх, зөрчил гаргах гэх мэт харш үйлдэл, гэмт санаа бодлыг урьдаас мэдэж, бэлтгэл, завдалтын шатанд таслан зогсоох нь хорих ангид гэмт хэрэг гаргуулахгүй байх нь чухал юм.

Доктор (Ph.D), профессор Д.Даваа-Очир бүтээлдээ хорих ангид гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд сэтгэл зүйч, эмч болон эмнэлгийн үзлэгт хамруулж байх нь чухал ач холбогдолтой гэж бичжээ. Хоригдлын дундаас гарч байгаа хэрэг, эрх зүйн зөрчлийн хэлбэр агуулга, шинж чанар, нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг нэг бүрчлэн судалж, урьдчилан сэргийлэх ажлын чиглэлийг тогтоох явдал ихээхэн ач холбогдолтой юм[12]. гэжээ.

Хорих ангийн харуул хамгаалалтын нөхцөл байдлыг судалж үзэхэд хорих ангийн аюулгүй байдалд хохирол учруулах, хэвийн үйл ажиллагааг алдагдуулах талаарх хоригдлуудын зүгээс явуулж буй сөрөг үйл ажиллагааг авч үзвэл:

-хорих ангийн газар зүйн байршил, албан хаагчдын тоо, хамгаалалтын бүсийн талаар судлах;

-хамгаалалтын тоног төхөөрөмжийг гэмтээх, ажиллагаагүй болгох талаар судлах;

-өөрийн хань хамсаатантай холбоо харилцаа тогтоохыг оролдох;

-хорих байгууллагын ажилтан, албан хаагчдыг өөрийн үйл ажиллагаандаа ашиглахаар сонирхох, энэ талаар идэвхтэй байдлаар ажиллах;

-хорих байгууллагын хэвийн үйл ажиллагаанд гаднаас халдах, үйл ажиллагааг алдагдуулахыг оролдох /хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон эрх чөлөөтэй байгаа хань хамсаатнаар дамжуулан/;

-хамт ял эдэлж буй хоригдлуудаас өөрийн “гал” бүлэглэл бий болгох, шаардлагатай тохиолдолд тэдгээрийг ашиглах, өөрийн гэмт ажиллагаанд татан оролцуулах, айлган сүрдүүлэх, дарамтлах, өдөөн турхирах, зорилготойгоор гал хам гэсэн халхавчтайгаар эрхшээлдээ байлгах;

-ял эдлэхээс зайлсхийх зорилготойгоор хорих ангиас оргон зайлах;

-ял эдлэхээс зайлсхийх зорилготойгоор амиа хорлох;

-урьд үйлдсэн гэмт хэрийг нуун дарагдуулах, худал ташаа зүйл ярих, төөрөгдүүлэх;

-өөрт ашигтай шийдвэр гаргуулах зорилгоор бие эрхтэндээ гэмтэл, учруулах, гэмтэл учруулахаар заналхийхлэх;

-хорих ангид мөрдөгдөх хууль, журам зөрчсөн орчин нөхцөл бий болгохыг санаархах;

[12] Д.Даваа-Очир. “Хорих ангийн ахуй дэглэмийн байцаагчийн гарын авлага”. УБ., 2010 он

-нийгэмд өрнөж байгаа зарим хөдөлгөөн, тэмцлийг хууль хэлбэрээр дэмжих, дэмжихийг уриалах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болгох;

-хорих ангийн үйл ажиллагаанд ноцтойгоор нөлөөлөх сөрөг цуурхал дэгдээх, мэдээлэл тараах;

-бусдыг өдөөн турхирах;

-ял эдэлж байгаа хоригдлууд нь алба хаагчдыг ашиглан өөрсдийн гэмт үйлдэл болон гадна байгаа гэмт хэргийн оролцогч, бусад этгээдүүдтэй холбоо тогтоох, хорих ангиас гэмт хэрэг удирдан зохион байгуулах, гэмт хэргийн хохирогч нарыг дарамтлах зэрэг байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх хорих байгууллагын үндсэн чиг үүргээс харахад пенитенциар гэмт явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хорих анги, байгууллагаас хэрэгжүүлж буй янз бүрийн чиглэл цар хүрээ, зохион байгуулалтаас бүрдэж байгаа нийгмийн цогц ажиллагаа гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Пенитенциар гэмт явдал, түүний зүй тогтлыг судалснаар хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үйлдэгдэж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, практик ажилтнуудаас гэмт хэрэгтэй тэмцэхэд туйлын ач холбогдолтой юм.

Дүгнэлт, санал:

1. Хорих анги, байгууллагын биечилсэн харуул хамгаалалт сул, хүн хүчний хүрэлцээ муугаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд сүүлийн 5 жилд нийт 19 гэмт хэрэг гарсан ба үүнээс оргох гэмт хэрэг 12 буюу 63.2 хувийг эзэлж байгаагаас харагдаж байна.

Техник, технологи өндөр хөгжсөн гадаад улсын практик туршлагыг судлан үзэхэд ХБНГУ, БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонг-Конгийн хорих байгууллагад теле хяналтын систем өргөн нэвтэрсэн хэдий ч хүний хүчин зүйл, биечилсэн хяналтыг орхигдуулалгүй 1 харуул хамгаалалтын ажилтан 6-8 хоригдолд биечилсэн хяналт тавин ажилладаг байна.

Хорих байгууллага нь нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгэгдсэн хүмүүсийн бөөгнөрөл тул тэдний зүгээс гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр байдаг. Батлагдсан орон тоогоор хамгаалалтын ажилтны тоо их харагдаж байгаа боловч ШШГБ-ын хэмжээнд 24 цагийн жижүүрлэлтэд **200-230** харуул хамгаалалтын ажилтан хоригдогд тавих

биечилсэн хяналт, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж, бусад хамгаалалтын ажилтан нь хорих ангийн гадна хамгаалалт, нэвтрэх хэсэг, хуяглан хүргэх ажиллагаа, үйлдвэрлэлд үүрэг гүйцэтгэдэг тул “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”[13]-д зааснаар хамгаалалтын ажилтны орон тоог нэмэгдүүлэх;

2. Хорих ял эдлэгсэдээс үйлдэж буй зөрчил, гэмт хэрэг бүгдийг цаг алдалгүй илрүүлэн таслан зогсоож хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг шуурхай явуулан шийдвэрлэж зөрчлийн болон хоригдлын хувийн байдалд нь тохирсон хариуцлагыг эргэлт буцалтгүй заавал ноогдуулах механизмыг нэг мөр төлөвшүүлэх.

Учир нь хорих байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн мэдээнд гэмт хэргийн шинжтэй зарим үйлдэлийг сахилгын төрөлд тооцон хариуцлага хүлээлгэдэг практик түгээмэл байна. /жишээ нь: хорих ангийн байрлалыг дур мэдэн орхиж явах, бусдын биед гэмтэл учруулах, танхайрах, хулгайлах гэх мэт/;

3. Шинэ төрлийн гэмт хэрэг буюу цахим гэмт хэрэг, авлига, албан тушаалын гэмт хэрэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хоригдлуудтай ажиллах мэргэшсэн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмнэлэг, хамгаалалтын ажилтнуудыг бэлтгэн шинэ төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.


Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг таньж илрүүлэх төхөөрөмжийг харуул хамгаалалтад нэвтрүүлэх, харуул хамгаалалтын техник хэрэгслийг тухай бүр шинэчлэн сайжруулах, тус чиглэлээр ажиллах алба хаагчдыг сурган, дадлагажуулж, энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хоригдлуудад тогтмол хяналт тавих тогтолцоог бий болгох;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 208 дугаар зүйлийн 208.3 дахь хэсэгт “*Анх удаа ял эдэлж байгаа хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, засарч хүмүүжиж байгаа хоригдлыг засарч, хүмүүжихгүй байгаа хоригдлоос, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн болон зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн гишүүнд тооцогдож ял шийтгүүлсэн*

[13] Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаал

хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ” гэж заасныг бүрэн хэрэгжүүлэх зэрэг болно.

ХОРИГДОЛД ОНОГДУУЛАХ САХИЛГЫН ШИЙТГЭЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ



Б.ОТГОНБАЯР
ШШГЕГ-ын харъяа Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн дарга, хошууч

Товч агуулга: Манай орны судлаачдын бүтээл, практик байгууллагын нийтэд зориулсан мэдээ тайлангаас үзвэл хоригдолд сахилгын шийтгэл хүлээлгэх асуудал ихэвчлэн хорих байгууллагын дэглэмийг сахиулах арга хэрэгслийн явцуу хүрээнд хөндөгдөн хэлэлцэгдсэн. Энэхүү илтгэлд хоригдолд оногдуулах сахилгын шийтгэл, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэнд тулгамдаж буй асуудлыг боловсронгуй болгох арга хэмжээг санал болгосон.

Abstract: The work of our country’s researchers according to the public report of the practical organization the issue of disciplinary action against detainees has often been discussed in the context of the narrow means of maintaining order in prisons.

The report proposes measures to improve disciplinary action against prisoners, legal regulations, and enforcement issues.

Түлхүүр үг: Хууль зүйн хариуцлага, удаан хугацааны уулзалт, утсаар ярих эрх,

Key word: Legal liability, long meetings, phone calls

Удиртгал

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд өрнөсөн их ажил шүүхийн шийдвэр гүйцэтгэх, түүний дотор хорих ял эдлүүлэх салбарыг хамарч нэлээд ажил өөрчлөлтүүд хийгдлээ. Хорих байгууллагын эрх зүйн үндсийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх нь тухайн нийгмийн амьдралд эерэгээр нөлөөлдөг юм.

Хоригдлыг дахин хүмүүжүүлэх, цээрлүүлэх зорилтуудын уялдаа холбоог орчин цагийн нийтлэг жишээг, урьдын уламжлалын хүрээнд байнга авч үзэх нь өнөө үед ч шаардлагатай хэвээр байна. Чингэснээр хүмүүнлэг, иргэний, ардчилан нийгэм байгуулах эрхэм зорилтын мөн

чанарыг энэхүү эмзэг чухал салбарын онцлогийг харгалзан тодорхойлж чадах юм. Тийм ч учраас хоригдолд оногдуулах сахилгын шийтгэлийн эрх зүй ёс суртахууны үндэс үйлчлэл, үр нөлөөг тусгайлан судлах нь зүйтэй гэж үзсэн юм.

Хоригдолд оногдуулах сахилгын шийтгэл нь анх 1931 онд батлагдсан “Монгол ард улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай хууль”-д анх тусгалаа олон хэрэгжэж ирсэнээс хойш 1966,1981, 1993, 1996,2002, 2008, 2017 онуудад батлагдсан хуулиудад тусгагдан өөрчлөгдөн шинэчлэгдсээр байна.

1966 онд батлагдсан “БНМАУ-ын засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн тухай хууль”-д гэхэд л хоригдолд оногдуулах сахилгын арга хэмжээг өргөн утгаар шингээн хуульчилж өгсөн нь хоригдлын дундаас гарч буй зөрчилд хүлээлгэх хариуцлагын хэлбэр тухайн үед чамлахааргүй түвшинд байсан нь ажиглагддаг хэдийгээр эрх зүйн зохицуулалт нь боловсронгуй болсоор ирсэн боловч өнөө үед хоригдлын дундаас гарах гэмт хэрэг, зөрчил жилээс жилд өсөх хандлагатай нь ажиглагддаг.

Хоригдолд оногдуулах сахилгын шийтгэлийн “Хоригдлыг спорт тоглоомд оролцох, кино, концерт үзэхээс нэг удаа хасах, ээлжит эргэлт, илгээлт авах эрхийг хасах буюу хүнсний зүйл худалдан авахыг нэг сар хүртэл хугацаагаар хориглох” гэсэн уламжлалт, үйлчлэл бүхий янз бүрийн төрлүүд үгүйлэгдэж байна.

Хоригдлын ахуй хангамж, орон байр, хоол хүнс дэлхийн жишигт дөхөж байгаач тэдний дундаас гарч буй зөрчил багасахгүй харинч тогтмол нэмэгдэж буй хандлагыг судлах нь өнөөгийн тулгамдсан зорилтын нэг. Мөн түүнд оногдуулж буй сахилгын шийтгэл, төрлүүд нь хоригдолд хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх, цээрлүүлэх, тэдний дундаас гарч болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйд нөлөөлөх чадвар улам бүр багасаж байгаа нь ажиглагдах болов.

Нөгөөтэйгүүр практик үйл ажиллагаанд хоригдолд оногдуулах сахилгын шийтгэлийн үр нөлөө, оновч муутайгаас дээр дурдсан сөрөг үзэгдэл төдийлөн буурахгүй байна гэх үндэслэл бий. Энэ нь хоригдолд оногдуулах сахилгын шийтгэлийн төрлүүдийг боловсронгуй болгох шаардлага тулгамдаж буйг харуулах үзүүлэлт ярианүй мөн. Иймээс энэхүү шийтгэлийн төрлүүдийг хоригдлуудын өдүүлж буй гэмт хэрэг, зөрчилтэй уялдуулан судалж боловсронгуй болгоход чиглэгдсэн санал дүгнэлт бэлтгэх зорилгоор энэхүү сэдвийг сонгосон юм.

1. Хоригдолд оногдуулах сахилгын шийтгэлийн тухай ойлголт

Хорих анги гэдэг нь манай улс дотор оршин тогтнож буй бас нэгэн онцлог бичил нийгэм юм. Гэтэл хоригдолд оногдуулж буй сахилгын шийтгэлийн төрлүүд болон зарим хэсгүүд нь өнөөгийн нийгэм буюу практик үйл ажиллагаанд тэр бүр нийцэхгүй байгаа нь ажиглагддаг.

Сахилгын шийтгэл гэдэг нь сахилгын зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын арга хэмжээ[1] гэж үздэг бол сахилгын зөрчил нь дагаж мөрдөж буй хууль тогтоомжид сахилгын хариуцлага хүлээлгэхээр заасан [2] хэм хэмжээгээр тодохойлогддог. Сахилгын шийтгэл нь хууль зүйн хариуцлагын нэг төрөл.

Юуны өмнө хоригдолд оногдуулах сахилгын шийтгэлийн үндэслэл нь юу болох вэ? Тухайлан авч үзэх нь зүй ёсны хэрэг. Нийгэмд амьдарч тодорхой төрлийн эрх зүйн харилцаанд оролцож буй бүх этгээд тэрхүү харилцааг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хүлээх нь ойлгомжтой.

Тэгвэл нийгэмд тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдэж нийгмээс тусгаарлагдаж хорих ялаар шийтгүүлсэн этгээд хууль тогтоомж, хорих ангид тогтоосон дэглэм, журам зөрчсөн нь гэмт хэргийн шинжгүй бол түүнд хорих ангийн даргын шийдвэрээр сахилгын шийтгэл оногдуулдаг.

Сахилгын шийтгэл оногдуулж буй гол зорилго нь

Нэгдүгээрт: бусад хоригдлуудыг сахилгын зөрчил гаргуулахгүй байх талаар авч буй урьдчилан сэргийлэх шинжийг агуулна,

Хоёрдугаарт: хоригдлын гаргасан зөрчилд хүлээлгэж буй хариуцлагын нэг хэлбэр,

Гуравдугаарт: тухайн хоригдлыг гаргасан зөрчилд нь гэмшүүлж цээрлүүлэх явдал юм.

Мөн хорих ялын дэглэмийн шаардлагыг хангахад нөлөөлөх нөгөө нэг үндсэн хэрэгсэл бол албадлагын арга хэмжээ.Энэхүү албадлагын арга хэмжээнд хоригдолд тавих бүх талын хяналт харуул хамгаалалт болон зайлшгүй тохиолдолд оногдуулах сахилгын шийтгэлийг хамааруулж [3] ойлгож ирсэн.

Иймээс ч хоригдолд албадлагын арга хэмжээг хэрэглэх нийтлэг болон тодорхой хугацаа байдгийг анхаарах шаардлагатай болдог.

---

[1]С.Нарангэрэл эрх зүйн эх толь бичиг УБ 2008 он 373 дахь тал

[2]Мөн толь 373 дахь тал

[3]А.Лхагва Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй УБ 2008 он 234 дэх тал

Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хорих ял шийтгүүлэн байгуулагын мэдэлд ирээд суллагдах хүртэл бүх хугацааны турш хоригдлыг бие болоод амьдрах байр, хөдөлмөрлөх орчинд төрөл бүрийн хяналт тавьдаг. Мөн хугацаанд хоригдлыг байнгын харуул хамгаалалтын хатуу чанд нөхцөлд байлгана. Энэ тухай эрдэмтэнсудлаачид ном, бүтээлдээ дурдсан байдаг. [4]

Хоригдолд албадлагын арга хэмжээ хэрэглэх тодорхой хугацаанд тэдний гаргасан сахилгын зөрчилд тохирсон аливаа сахилгын арга хэмжээ оногдуулж эдлүүлэх, эд материалын хохиролыгарилгуулах хүртэлх үе хамрагдана. Дэлгэрэнгүй авч үзэхэд.

2017 оны шинэ хуульд Хоригдолд гаргасан зөрчилд тохируулан хорих ангийн даргын тушаалаар дараах сахилгын шийтгэл оногдуулдаг. Үүнд:

1. Хоног, сар, улирал, жилд авах түр, удаан хугацааны уулзалт, эсхүл утсаар ярих эрхийг 3 сар хүртэл хугацаагаар хасах

2. Сахилгын байранд хорих

3. Тухайн сар, улирал, жилд олгосон шагналын хоногийг хасах гэсэн төрлүүдтэй байна.

Хоригдлыг сахилгын хорих байр, тусгаарлах тасалгаанд хорихдоо Улсын ерөнхий прокурортой зөвшилцөж, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлан гаргасан журмыг баримтлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог.

Хоригдлууд ял эдэлж байхдаа Монгол улсын Эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэргийн шинжүүдийг агуулсан үйлдэл гаргадаг. Үүнд болон цагдан хорих байрнаас оргох, хорих ял эдлэхээс зайлс хийх, хорих ангийн захиргааны шаардлагад зориуд захирагдахгүй байх, төрийн албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх, доромжлох, дайрч довтлох, гэх зэрэг гэмт хэрэг үйлдэх явдал нэлээдгүй гардаг нь нууц биш юм.

Хоригдлыг сахилгын хорих байр, тусгаарлах тасалгаанд хорихдоо Улсын ерөнхий прокурортой зөвшилцөж, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлан гаргасан журмыг баримтлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог.

[4]С.Нарангэрэл БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүйн үндсэн асуудал УБ 1985 он
А.Лхагва, С.Жанцан Монгол улсын эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн УБ 1996 он

2. Хоригдолд оногдуулах сахилгын шийтгэлийн эрх зүйн зохицуулалт

Уг харилцааны эрх зүйн өнөөгийн зохицуулалтын зарим хэм хэмжээ нь амьдралд нэг мөр хэрэгжиж хэвшээгүй, эсхүл хэрэгжих боломжгүй, нөгөө талаар төрийн эрүүгийн бодлогын мөн чанар, олон улсын эрх зүйн нийтлэг /жишиг/ хэм хэмжээ, чиг хандлагатай зөрчилдсөн, шийдвэрлэх цөөнгүй асуудалтай болох нь судалгаанаас харагдлаа. Тухайлбал:

Монгол улсад хорих ял шийтгэгдэж хорих ял эдэлж буй нийт зургаан мянга (олон жилийн дундаж тоо) гаруй ялтан байдаг бөгөөд сүүлийн арван жилийн байдлаар төвлөрсөн хорих ангиудад давхардсан тоогоор нийт 8000 дээш хоригдол зөрчил гаргаж сахилгын шийтгэл эдэлсэн байна. Нийт зөрчлийн 97% нь хоригдлоос, 3% нь хоригдогчоос тус тус гарчээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны хоригдогсдын шилжилт хөдөлгөөн, тоо бүртгэлийн бүртгэлийн мэдээ, судалгаа, тайлан 2011-2017 он хүртэл 7 жилийн судалгаа.

Хоригдлийн зүгээс нийт 474 зөрчил гарснаас алба хаагчийн хууль ёсны шаардлага эсэргүүцсэн 111 буюу 24 хувь, бусдыг зодож дарамталсан 90 буюу 19 хувь, гар утас ашигласан ашигласан 69 буюу 15 хувь, хориотой эд зүйл хадгалсан 83 буюу 18 хувь, эд зүйл булаасан, дээрэмдсэн 11 буюу 3 хувь, бусдын биед гэмтэл учруулсан 16 буюу 4 хувь бусад зөрчил 17 хувийг эзэлж байна.

Хоригдлоос гаргасан зөрчлийн төрөл

Д/д	Зөрчил	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	**Нийт**
1	Албан хаагчийн хууль ёсны шаардлага эсэргүүцсэн	14	17	15	8	10	20	27	**111**
2	Бусдыг зодож дарамталсан	13	8	10	18	12	4	25	**90**
3	Гар утас ашигласан	17	8	2	17	16	5	4	**69**
4	Хориотой эд зүйл хадгалсан	12	16	15	2	1	19	18	**83**

5	Эд зүйл булаасан, дээрэмдсэн	8	-	2	-	1	-	-	**11**
6	Бусдын биед гэмтэл учруулсан	-	6	-	-	1	9	-	**16**

Иймд хоригдлын гаргасан зөрчил жил жилээр хурдацтай нэмэгдэж байгаа явдлыг зогсоох хэвийн хэмжээнд барих явдал нэн тэргүүний шаардлагатай чухал асуудал болоод байгаа юм.

Хоригдлын зөрчил нь хорих ангийн хэвийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг гэж үзэж болно.

Тухайн хорих ангид ял эдэлж буй хоригдлын хөдөлмөрлөх, хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх үйл ажиллагааг хорих анги, ангийн удирдлага, албан хаагчид шууд хариуцан явуулдаг бөгөөд хоригдлын гаргасанзөрчлөөс хамааран тухайн хоригдлын ажлын байр эзгүйрэх, тус ангийн хэвийн үйл ажиллагаа доголдох, зэрэг асуудлууд үүсдэг. Иймд хоригдлын зөрчил гаргах шалтгаан, гаргасан зөрчлийн хор аюул хамрах хүрээнээс шалтгаалан хорих ангийн даргын тушаалаар сахилгын шийтгэл оногдуулдаг.

Оногдсон сахилгын шийтгэлийн арга хэмжээ нь тухайн хоригдлыг гэмшүүлэх дахин зөрчил гаргуулахгүй байх талаар ойлгуулах, үүгээр дамжуулан бусад хоригдлын сэтгэл зүйд нөлөөлж, цочрол өгөх зэрэг олон талын хийсвэр ухагдахуун боловч практик үйл ажиллагаан дээр энэ нь хэрэгжэхгүй байгаатай холбоотой хоригдлын гаргах зөрчил болон гэмт хэрэг буурахгүй байгаа билээ.

Сүүлийн жилүүдэд хоригдлын эрхийг хамгаалах, хүний эрх эрх чөлөөг дээдэлсэн бодлогууд ихээр явагдаж хорих анги болон бусад салбар нэгжүүдэд хоригдлын эрхийг хангах хамгаалах олон талын үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагууд хэрэгжүүлж ирсэн бөгөөд үүнтэй холбоотой хоригдолд оногдуулах сахилгын шийтгэлийн асуудал хөндөгдөж байсан юм.

Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 227 дугаар зүйлд хоригдолд оногдуулах сахилгын шийтгэлийн талаар хуульчилж эрх зүйн зохицуулалт хийгдсэн байдаг.

Хоригдол хууль тогтоомж, хорих ангид тогтоосон дэглэм, журам зөрчсөн нь гэмт хэргийн шинжгүй бол түүнд хорих ангийн даргын шийдвэрээр дараах сахилгын шийтгэл оногдуулдаг. Үүнд:

- Хоног, сар улирал, жилд авах түр, удаан хугацааны уулзалт эсвэл утсаар ярих эрхийг 3 сар хүртэл хугацаагаар хасах
- Сахилгын байранд хорих
- Тухайн сар, улирал, жилд олгосон шагналын хоногийг хасах.

Хорих ангийн үйлчилгээнд сахилгын шийтгэлийн хэлбэрээр ажиллуулахыг Нэгдсэн Үндэсний Байгууллагаас батлан гаргасан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”-д хориглосон заалт байдаг. Нөгөөтээгүүр хоригдлын хөдөлмөрлөх цаг хугацааг тогтоосон эрх зүйн зохицуулалт манайд байдаг. 2012-2017 он хүртэл сүүлийн 5 жилийн судалгаанаас үзэхэд нийт 2544 хоригдолд ээлжийн бус ажил хийлгэх сахилгын шийтгэлийгоногдуулсан тоо баримт байна. Хоригдолд хорих дэглэмээс хамаарч сахилгын шийтгэл оногдуулах эрх зүйн орчин мөн өөр өөр байна. Хорих ял эдлүүлэх дэглэм нь хоригдлыг хүмүүжүүлэхэд нөлөөлөөд зогсохгүйхорих анги, гяндан, баривчлах байранд хоригдлуудаас гэмт хэрэг шинээр үйлдэхээс урьдчилан сэргийлэх явдлыг хангана.

Хорих ял эдлүүлэх дэглэм нь, ялын цээрлэл үзүүлэх, шууд илэрхийлэл болохын хувьд иж бүрэн эрхийн хязгаарлалтуудад илэрч байдаг. Хоригдлын эрхийн байдлыг тодорхойлдог. Энэ байдал нь хоригдол хорих ял эдэлж байх хугацаандаа иргэний эрхээ бүрэн эдлэх боломжоо хязгаарлуулж байгаа нь ажлын цээрлэл амсаж байгаа хэрэг юм.

Дэглэмийн тусламжтайгаар ялын цээрлэлийг хэрэгжүүлэх нь гол зорилго гэж үздэг. Цээрлэл нь аливаа эрүүгийн ялд байх элемент бөгөөд энэ нь гагцхүү хүмүүжүүлэх агуулгатай юм. Өөрөөр хэлбэл хоригдолд цээрлэл үзүүлэх замаар дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байлгахад Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан нэг зорилго оршино.

Эрхийн хязгаарлалтууд нь цээрлэлийн агуулгатай боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн нөлөөллийн бусад арга хэмжээнүүдтэй нягт холбоотойгоор хэрэгжиж, хорих ял эдлэгсэдийг нийгэмд тогтоосон нийтээр дагаж мөрдөх хууль ёсыг сахин биелүүлдэг, аливаа асуудалд тэвчээртэй ухаалаг ханддаг болон хоригдлыг хүмүүжүүлдэг болохыг практик харуулж байна.

Үүнээс үндэслэн дэглэмийг зөвхөн хоригдлыг цээрлүүлэх хэрэгсэл гэж үзэж болохгүй бөгөөд дэглэм нь бүхэлдээ тэдний үйлдсэн гэмт хэрэг, зан байдлын хувьд харилцан адилгүй олон тооны хоригдлуудыг нэг дор амьдрах нөхцөлийг бүрдүүлээд зогсохгүй, хоригдол бүрийн алхам тутамдаа биеэ авч явах журам, амьдралын хэв маягийг нарийвчлан тогтоох замаар

тэднийг хамтын хөдөлмөр хийлгэж, улмаар хөдөлмөрөөр хүмүүжүүлэх, тэдний дунд хүмүүжлийн ажил, боловсролын сургалт, хөдөлмөрийн дадлага олгох сургалт зохион байгуулах нөхцөлийг хангаж байдгаараа хүмүүжлийн чухал хэрэгсэл юм. Олон хүн цугларсан газар тэр тусмаа гэмт хэрэгтнүүдийн бөөгнөрөл болсон хорих байгууллагад хатуу дэг журамгүйгээр ялын зорилго хангагдахгүй харинч тэдний дундаас гарах зөрчил гэмт хэрэг гарах нөхцөл бололцоог олгож буй хэрэг гэдгийг 97 жилийн түүхэн туршлага харуулж байна.

Дээрх дэглэмийн талаар хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан “Дэглэм нь ялтны зүгээс гаргаж болох хууль бус үйл ажиллагаагхязгаарлаад зогсохгүй түүнийг нийгмийн идэвхтэй гишүүн болгон эрх чөлөөт амьдралд буцаан оруулах замаар амьдралын ердийн нөхцөлд үргэлжлүүлэн хүмүүжүүлэхэд чиглэгдсэн чухал элементүүдийг өөртөө агуулдаг. Жишээ нь: Хоригдол тогтоосон цагийн хуваарийг ягштал биелүүлэх, өглөө бүр биеийн тамирийн дасгал хийх, орчны хүмүүсийг хүндэтгэдэг, зөв боловсон харьцдаг болохыг шаардсан дэглэмийн элементүүд цэвэр хүмүүжлийн агуулгатай байна.

Гянданд ял эдэлж буй хоригдол анх удаа сахилгын зөрчил гаргасан тохиолдолд түүнд 2008 оны хуулиар ээлжийн бус ажил хийлгэх сахилгын шийтгэл оногдуулах нь зохимжгүй харин 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийнхоног, сар улирал, жилд авах түр, удаан хугацааны уулзалт эсвэл утсаар ярих эрхийг 3 сар хүртэл хугацаагаар хасах сахилгын шийтгэл бол нүдээ олсонбөгөөд тусгай нэгжид /гяндан/ хоригдож буй хоригдлуудад хөдөлмөр эрхлэх боломж бололцоо одоогоор манайд алга байна.

2012-2017 он хүртэл сүүлийн 5 жилд 564 хоригдолд хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх арга хэмээ авсан бол 2393 хоригдолд сахилгын хорих байранд хорих 1155 хоригдлын шагналын хоног хасах сахилгын арга хэмжээ авагдсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 228.1. Насанд хүрсэн эрэгтэй хоригдлыг 30 хүртэл хоног, эмэгтэй хоригдлыг 15 хүртэл хоног, онцгой тохиолдолд эрэгтэй хоригдлыг 60 хүртэл хоног, эмэгтэй хоригдлыг 30 хүртэл хоног сахилгын байранд ганцаарчлан хорихоор заасан байдаг.

Мөн хорих ангийн аюулгүй байдлыг хангах, хоригдлын дундаас гарч болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ангийн жижүүрийн шийдвэрээр тухайн хоригдлыг 72 цаг хүртэл сахилгын

хорих байранд шилжүүлж болдог бөгөөд хоригдлыг сахилгын хорих байранд хорих тохиолдолд заавал эмчид үзүүлж тэмдэглэл үйлдсэн байх шаардлагатай байдаг.

Хоригдлын дундаас гарч буй зөрчлийг бууруулах гол үндсэн арга бол хоригдлыг хүмүүжүүлж, нийгэмшүүлэх явдал юм. Хорих ангийн нөхцөлд хоригдлыг хүмүүжүүлэх гол арга бол хөдөлмөрлүүлэх нь зөв оновчтой арга юм.

Хоригдолд оногдуулж буй сахилгын шийтгэлийн өнөөгийн орчин нь хорих ял эдлэгсдийн дундаас гарч буй зөрчлөөс шууд хамаарч буй нь ойлгомжтой.

Эрүүгийн хуульд заан тодорхойлсон нийгэмд аюултай, эс аюултай үйлдлийг хийж бусдад ямарваа нэгэн хэлбэрээр эд материалын болон сэтгэл санааныхохирлыг их, багахэмжээгээр учруулж, үүний улмаас Үндсэн хуульд заасан заяагдмал эрхээс бусад тодорхой эрхүүдийг хязгаарлаж, төрийн хуулийн дор суугаа этгээдийн талаарх анхаарах зарим асуудлуудыг авч үзэх нь зүйтэй. Тухайн хоригдлыг хорьж цагдсанаар гэмт үйлдлийг ойлгуулах, нийгмийн хор уршиг аюулыг бүрэн гүйцэт таниулах, цаашид дахин гэмт хэрэг үйлдэхгүй гэх баталгаа бүрэн хангагдаж чадахгүй байна. Өнөөгийн нийгэм дэх бодит байдал дээр энгийн буюу эрх чөлөөт иргэдээс авахуулаад нийгмийн тодорхой хэсэг, бүлэг хүмүүст ажлын байр олдохгүй, олдсонч тухайн ажлын байранд ажлын дадлага туршлага, нас, мэргэжил, боловсрол зэрэг наад захын шалгуур үзүүлэлтийг тавьж, үүнийг хангах шаардлага гарч байна. Энэ нь зах зээлийн бичигдээгүй хуулийн дагуу тавьж буй тодорхой хэрэгцээнд тулгуурласан ойлголт билээ.

Дүгнэлт:

Энэ бүхнээс үзэхэд хоригдлуудын дундаас гарч буй зөрчил улам бүр ихэсч, мөн арга хэрэгсэл нь улам бүр нарийсаж байгаа нь практик үйл ажиллагаан дээр ажиллаж буй албан хаагчдын илрүүлэн хураан авсан эд зүйлс, баримтжуулж авсан эд материалаас тод томруун харагдаж байна. Иймд хоригдолд оногдуулах сахилгын шийтгэлийг чангатгах шаардлага тулгарч байгаа нь тулгамдаж буй асуудлуудын нэг гэж үзэж байна.

Санал.

Манай оронд хоригдолд хүлээлгэх сахилгын шийтгэл хэлбэр, төрөл, тооны хувьд цөөн учраас зөрчилд тэр бүр тохирсон шийтгэл хүлээлгэх боломжийг хязгаарладаг. Хүүхдийн бие физиологи, сэтгэл зүй, хөгжлийн

зэрэг онцлогтой нь уялдуулан тэдэнд хүлээлгэх сахилгын шийтгэлийн тусгай төрлүүдийг нэрлэж хуульчлах.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. С.Нарангэрэл эрх зүйн эх толь бичиг УБ 2008 он 373 дахь тал
2. А.Лхагва Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй УБ 2008 он 234 дэх тал
3. С.Нарангэрэл БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүйн үндсэн асуудал УБ 1985 он
4. А.Лхагва, С.Жанцан Монгол улсын эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн УБ 1996 он

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДЛУУД



Б.БАТЗАЯА
ШШГЕГ-ын харъяа Ховд аймаг дахь ШШГГ 457 дугаар нээлттэй хаалттай хорих ангийн ээлжийн дарга, ахлах дэслэгч

Товч агуулга: *Бие хүн, нийгэм, улс гүрний амин чухал ашиг сонирхол дотоод, гадаадын аюул, заналхийллээс үндсэн болон бусад хууль тогтоомжийн мөрдөлт, практик үйл ажиллагааны үр дүнд баталгаатай хамгаалагдаж, хангагдсан байдлыг судлах*

Abstract: *The research of vital convenience of country, society and and individual; the following of the constitution, other laws and legislations for inner and outer threats; to research granted protection in the result of practice activities.*

Түлхүүр үг: *Аюулгүй байдлын онол, арга зүй, судлах зүйл, тогтолцоо, объект, субъектийн асуудлыг судалж, практик ажиллагаанд нэвтрүүлэх*

Key words: *To research problems of object and subject, system, thing to study, method and theory of safety; introduce to practice activities.*

Хүн төрөлхтөн туулж өнгөрүүлсэн амьдралынхаа учир утгын талаар олон зууны туршид өөртөө асуулт тавьсаар ирсэн түүхтэй. Бусад салбарын олон философич, эрдэмтэд үзэхдээ, хүн төрөлхтний удмын сан, залгамж чанарыг үргэлжлүүлэх, хүмүүсийн амьдралыг тэтгэх, хадгалах нөхцөлийг хангахад оршино хэмээн тайлбарлаж ирсэн байна. энэ зорилгод хүрэх нь хүмүүс, нийгэм, улс гүрэн, хүн төрөлтний амьдрал, үйл ажиллагааны аюулгүй байдлыг бүхэлд нь хангах асуудлын хэрэгцээ, шаардлага, ач холбогдлыг юун түрүүнд тодорхойлохыг нөхцөлдүүлж өгч байна.

Аюулгүй байдлыг хангах хэрэгцээ, шаардлага нь хүмүүс, нийгэм хамтлагийн үйл ажиллагааны үндсэн шалтаг болж ирснийг түүхэн туршлага гэрчилдэг. Аюулгүй байдлыг хангах хүсэл эрмэлзэл нь бидний өвөг дээдсээс эхлээд хүн төрөлхтөн олон арван хүчний бүтэц, байгууллага, арми, цагдаа, хамгаалалтын албад, гэнэтийн гамшиг сүйрлээс сэргийлэн хамгаалах хүчин зэрэгт нэгдэн эвсэлдэхийг нөхцөлдүүлж, дэлхийн бүх хүн

амын аюулгүй байдлыг хангах зорилго бүхий олон улсын хэдэн зуугаар тоологдох байгууллагууд, түүний дотор НҮБ-ыг үүсгэн байгуулахад хүргэж ирсэн түүхтэй. Аюулгүй байдлын тогтолцоо сул дорой байх нь хүн төрөлхтнийг хэмжээлшгүй хүнд зовлон зүдүүрт хүргэж ирснийг түүх гэрчилнэ. Улс гүрэн мөхөж сөнөх, ард түмэн устаж үгүй болох, нөхөж баршгүй цус асгаруулсан дайн байлдаанд хүмүүс нэрвэгдэж туйлдах, эд материалын үнэт зүйлс устгагдаж үгүй болох зэрэг нь аюулгүй байдлын тогтолцоо бүрэлдэж, найдвартай болоогүйн хор уршиг, бодит жишээ болж байна.

Аюулгүй байдал нь аливаа улс орны үндэсний язгуур эрх ашигтай шууд холбогдоно. Үндэсний аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь тасралтгүй үргэлжлэх үйл явц мөн. Тиймээс Үндэсний аюулгүй байдлын мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээ ч тасралтгүй хийгдэж байх учиртай. Аюулгүй байдлын асуудал Олон улсын харилцааны үндсэн судлагдахуун юм.

Монгол Улсын иргэн бүр үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно. Үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн анхдагч үүрэг мөн. Иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэгтэй байх, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах, хамтран ажиллахад төр онцгой анхаарна. Монгол Улсын "оршин тогтнохуйн аюулгүй байдал", "эдийн засгийн аюулгүй байдал", "дотоод аюулгүй байдал", "хүний аюулгүй байдал", "хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал", "мэдээллийн аюулгүй байдал" харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна. Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна. Болзошгүй аюул, сорилтыг бодитой тодорхойлж, тэдгээрийг гэтлэн давахад хязгаарлагдмал нөөц, боломжийг үр дүнтэй дайчилна. Даяаршил улс үндэстний бусдаас хамаарах эмзэг байдлыг нэмэгдүүлж, нөгөө талаас гадаад нөөц боломжийг ашиглан үндэсний ашиг сонирхлоо хамгаалж бататгах боломж олгож байна.

1. Аюулгүй байдлын онол, үзэл баримтлалууд, шинжлэх ухааны үүсэл хөгжил

Шинжлэх ухаан бүхий л цаг үед ертөнцийг цул нэгдмэл хэмээн төсөөлөхийг зорьсоор иржээ. Эйнштейн хүртэл энэ зорилгыг өмнөө тавьж, онолын физик, математикийн нэгдсэн хуулиудыг нээхийг чармайж, “энэхүү хуулиудыг нээснээр ертөнц байгалийн бүх үзэгдэл, түүний дотор амьдрахуйн бүхий л талыг ухаалгаар төсөөлөх аргаар зураглан тодорхойлох үндэс тавигдана” хэмээн бичиж байсан ажээ. Тэрээр бичихдээ “Хэрвээ хүн төрөлхтөн физик, биологи, психологи, социологи, зэрэг бүх шинжлэх ухааны ерөнхий үндсийг нээж чадвал үнэхээрийн гайхамшигт үйлс болно” гэжээ.[1]

20 дугаар зуунд дэлхий ертөнц нэг цул нэгдмэл тогтолцоо болох тухай суурь ойлголтыг цаашид хөгжүүлэхэд түлхэц өгөхүйц уламжлалт шинжлэх ухааны салбарууд өөр хоорондоо сүлэлдэн нэгдэж, шинжлэх ухааны шинэлэг салбарууд нээгдсэн зуун байв.

Шинжлэх ухааныг интеграцчилах чиглэлд явуулсан судалгааны үр дүнд хэд хэдэн хавсармал шинжлэх ухааны салбарыг нээж бий болгох боломж бүрэлдсэн байна. тухайлбал:

Информациологи- дэлхий ертөнц мэдээллийн нэгдсэн орон зайд оршин тогтнох тухай шинжлэх ухаан

Ноокосмологи- дэлхий ертөнц нэгдмэл тогтоц болох тухай шинжлэх ухаан

Акмеологи- хүний хөгжлийн зүй тогтлын тухай шинжлэх ухаан

Эпилоги- байгаль дахь амьд болон амьд бус биет хоорондын эрчим мэдээллийн солилцооны тухай шинжлэх ухаан

Соционик- мэдээлэл эрчимжилтийн нэгдмэл организмын тухай шинжлэх ухаан зэрэг гэх мэт

Аюулгүй байдлын тухай ойлголт нь ихээхэн цогц шинжтэй үзэгдлийн мөн чанарыг тайлж, тодорхойлохоос эхлэх учиртай бөгөөд тухайлбал, аюулгүй байдал нь эдийн засаг, цэрэг, улс төр, мэдээлэл, боловсрол, генетикийн гэх мэт олон талтай ч эдгээрийг шууд эсвэл тусгайлан авч үзэх үндэслэлгүй онцлог шинжийг өөртөө агуулдаг ажээ.

Нийгмийн аюулгүй байдал л гэхэд тухайн нийгмийн бүтэц, бүрэлдэхүүний олон төрөл аюулгүй байдлын хэлбэр, маягийн нийлбэр биш бөгөөд зөвхөн өөрийн хэв шинжийг агуулсан онцлогтой байдаг жишээтэй.

[1] А.Карпов. Становление науки о безопасности. Безопасность, № 10-12, М.-1997

Хэдийгээр аюулгүй байдлын олон тал, тухайлбал, эдийн засаг, улс төр, байгаль орчин, цэргийн зэрэг нь бусад салбар шинжлэх ухааны боловсруулах асуудал байдаг ч шинжлэх ухааны эдгээр салбар бүхэн аюулгүй байдлын ерөнхий онолыг боловсруулахад өөр өөрийн хувь нэмрийг оруулах зүй тогтолтой. Аюулгүй байдлыг хангах асуудал хүмүүс, нийгэм, улс гүрэн, дэлхийн хамтлагийн үйлсэд тулгуурлана. Өөрөөр хэлбэл амьд ертөнц, хүн төрөлхтний хөгжил дэвшилд заналхийлж болзошгүй аюулыг судалж, илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, сулруулж саармагжуулж, таслан зогсоох, устгаж үгүй хийхэд хүн төрөлхтний ухамсарт ажиллагаа чиглэгдэж байх учиртай. Иймд аюулгүй байдлыг хангах асуудлыг шийдвэрлэх шинжлэх ухааны салбар тусдаа байх зайлшгүй шаардлагатай бөгөөд энэхүү салбар нь нэгэнт хөгжиж ирсэн бусад шинжлэх ухааны ололтод тулгуурлан хөгжих зүй тогтолтой ажээ.

Өнөөгийн шатанд энэ чиглэлд анхны алхмууд хийгдэж байгаа гэж үзэж болох ч хүн төрөлхтний ирээдүйн амьдралын асуудал хоёр дахь мянганы босгон дээр улам бүр хурцаар тавигдах болсон нь амьдрахуйн аюулгүй байдлын шинжлэх ухааныг хөгжүүлэх шаардлагыг нэмэгдүүлж байна.

Аюулгүй байдлын ерөнхий онолын үндэслэлийг боловсруулахад хүргэж байгаа хэд хэдэн урьдчилсан нөхцөл бүрэлдсэнийг дурдъя

Хүмүүс, нийгмийн бүлэг, нийгэм, улс гүрэн, дэлхийн хамтын нийгэмлэг аюулгүй байдлын тогтолцооны хүрээнд өөрийгөө, тэрчлэн байгаль, нийгмийн гарвал бүхий амин чухал объектууд болон үнэт зүйлсийг хадгалах, хөгжүүлэх бодит хэрэгцээ өсөн нэмэгдсээр байгаа.

Аюулгүй байдлын нэгдмэл тогтолцоо бүрэлдээгүй нөхцөлд хүмүүс болон амин чухал объектууд бусдаас ихээхэн хамааралд байх болсон.

Сөрөг нөлөөллийн тоо хэмжээ өсөн нэмэгдэхийн хэрээр төрөл бүрийн аюул занал даяарших агуулгатай болж байгаа зэрэг нөхцөлүүд бий болжээ.

Аюулгүй байдлын ерөнхий онолын хүрээнд боловсруулбал зохих чухал асуудлуудын нэг нь аюулгүй байдлын тогтолцооны сонгомол бүтцийг бий болгох, энэхүү тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан ажиллагаа, тэдгээрийн зорилго, үүрэг, эзлэх байр суурийг үндэслэлтэй тодорхойлох асуудал юм.

Үүнээс үзэхэд өөрийгөө хамгаалах болон амьдралын эх булаг болох байгаль орчны аюулгүй байдлын төлөө тэмцэгч хүний үйл ажиллагааг судалгааны объект, судлан шинжлэх зүйлээ болгодог аюулгүй байдлын

ерөнхий онол нь байгаль, нийгэм, техникийн зэрэг олон зүйл шинжлэх ухааны хүчин чармайлтаар бүрэлдэж, хамтын судалгааны бүтээгдэхүүн болдог байна. иймд амьдрахуйн аюулгүй байдлын судлал, шинжлэлийн тусгай салбарыг бий болгож, амьдралд бүтээлчээр ашиглах нь хүн төрөлхтний нэн чухал хэрэгцээ юм. Аюулгүй байдал нь хүн, нийгэм, улс гүрэн, нийт хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг, язгуур гарлын, эхний ээлжийн, тэргүүлэх зэргийн хэрэгцээ, зүй тогтлын нэг учраас түүний онолын үндсийг боловсруулахад хүнийг судалгааны объект, субъект болгож, хүний нийгмийн хөгжлийн ерөнхий зүй тогтлыг судлан шинжилдэг нийгмийн философийн шинжлэх ухаан тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирсэн байна.

Аюулгүй байдлын тогтолцоонд хүний эзлэх байр суурь нь амьдралд эзэлж байгаа орон зай, гүйцэтгэж буй үүрэг, ая холбогдлоос хамаарч байдаг.

Ихэнх тохиолдолд аюулгүй байдлын судалгааны объект нь хүн өөрөө байдаг ч судалгааны объект нь байгаль, техник хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгө, баялаг болон иргэд, нийгэм, улс гүрний бүрэн эрх, хуульчлагдсан ашиг сонирхол байх нь түгээмэл асуудал юм.

Тэрчлэн тухайн хүн тодорхой нөхцөлд аюул заналын субъект болохын зэрэгцээ мөн объект ч болох тохиолдол байдаг.

Аюулгүй байдлын олон төрөл, олон талт байдал, олон хүчин зүйлээс шалтгаалах зэргээс үндэслэн шинжлэх ухааны бүхий л цогц асуудлыг багтааж үзэх зорилгоор эрдэмтэд аюулгүй байдлын шинжлэх ухааныг секьюритологи хэмээн нэрлэх нь оновчтой гэж үзсэн байна.

“Секьюритологи” гэсэн нэр нь секьюрити-аюулгүй байдал гэсэн латин үг, лагас- үг, сургаал гэсэн грек үгний нийлбэр буюу орчуулбал “Аюулгүй байдлын шинжлэх ухаан” гэсэн агуулгыг илэрхийлнэ. Секьюрити гэсэн үг нь аюулгүй байдлын агуулга бүхий хамгаалалт, бэхлэлт, найдвартай чанар, хамгаалах, нууцлалт, хангалт, бүрэн бүтэн байдал, хадгалах, найдвар, аюулгүй байдлын байгууллага, сөрөг тагнуул зэрэг олон утгыг илэрхийлж байна.

Аливаа шинжлэх ухааны үндсэн үүрэг нь судалж буй асуудлынхаа мөн чанар, хөгжлийн зүй тогтол болон тэдгээрийг амьдралд хэрэгжүүлэх арга замын тухай онолын хувьд нэгтгэж, системчилсэн бодитой мэдлэг бий болгоход чиглэгддэг, амьдрахуйн аюулгүй байдлын шинжлэх ухаанд нэгэн адил үйлчилж байдаг.

Аюулгүй байдлын шинжлэх ухааны үндсийг бүрдүүлж бий болгохын тулд дараах асуудлыг цогцоор судлан шинжлэх шаардлагатай юм.

-Хүмүүс, улс гүрэн, дэлхийн хамтын нийгэмлэг өөрсдийн аюулгүй байдлыг хангах талаар хуримтлуулж буй туршлагыг судлах.

-Аюулгүй байдлын тогтолцооны зүй тогтол, бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан хамаарал, зарчмуудыг нээн илрүүлэх.

-Янз бүрийн нийгмийн байгуулалттай улс гүнүүд дотоод, гадаад аюулгүй байдлаа хангах чиглэлээр өөрсдийн онцлогийг тусгасан үйл ажиллагаа явуулж байгааг харьцуулан судлах.

-Дэлхий бүс нутаг, улс гүрний хэмжээний үндсэн аюул, занал болон аюулгүй байдлын ирээдүйн тогтолцооны хувьсал, өөрчлөлт, болзошгүй хувилбаруудыг шинжлэн судлах

-Эдгээр хувьсал, өөрчлөлт, хувилбаруудын боломжийг үнэлж, дүн шинжилгээ хийх.

-Аюулгүй байдлын ирээдүйн тогтолцооны үзүүлэлт, хэмжүүр үнэлэмжийн идэвх, чадамжид үнэлгээ өгөх зэрэг болно.[2]

Эрдэмтэн В.И.Ярочкин “Аюулгүй байдал гэдэг нь цэвэр философийн ойлголт гээд энэ нь бодитой, материаллаг байдлаар амьдралд тусгалаа олохгүй, харин бодит ертөнцийн амьдрах чадвар, амьдралын тэсвэрлэх чанарыг ямар нэгэн хийсвэр хэлбэрээр илэрхийлж байдаг хэмээсэн нь өрөөсгөл юм” хэмээн бичжээ.[3]

Эрдэмтэн И.Д.Козаков аюулгүй байдлын асуудлыг авч үзэхдээ синергетик буюу “өөрийгөө төвхнүүлэх” хандлагыг урьдал болгосон байх юм. Тэрээр бичихдээ: “Салбар шинжлэх ухаан хоорондын тухай мэдлэг болон аюулгүй байдлын танин мэдэхүйн онцлог бүхий хам хөгжлийн нэгдэл нь синергетик хандлагыг агуулна. Синергетикийн үндэслэлийн тухай философийн судалгааны дүгнэлт нь юугаараа үнэ цэнтэй вэ? Гэвэл, “өөрийгөө төвхнүүлэх” онол нь хүмүүнлэгийн тухай мэдлэг, түүний дотроос социологи, нийгмийн психологи, соёлын салбарт нэн хүчтэй түрэн орж ирж ирсэн явдал юм. Хамгийн их ач холбогдолтой зүйл нь аливаа нийгмийн иж бүрдлийн үүсэж бий болсон болон найдвартай оршин тогтнох үйл явцыг дүрслэн үзүүлэхдээ математик загварчлалын шугаман бус аргачлалыг юун түрүүнд ашигласан оролдлого, үүнийхээ үндсэн дээр эдийн

[2] Ч.Улаанхүү . “Аюулгүй байдлын үндэс”. УБ., 2016. 13-21 дэх тал
[3] В.И.Ярочкин. Секьюритология, “Ось-89”. 2000., с. 25

засаг, улс төр, соёл, боловсрол зэрэг нийгмийн цогц хөгжлийн тогтвортой байдлыг судлах аргуудыг боловсруулсан юм.

Эрдэмтэн И.Шершнев, “Аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалын үндэс, түүний бүтэц, механизмд улс орны зорилго, амин чухал ашиг сонирхол, суурь үнэт зүйлсийн тухай Ноосферийн шинэ ойлголтууд болон дэлхийн хамтын нийгэмлэгт түүний эзлэх байр суурь, үүргийн тухай асуудал тусгалаа олсон байх учиртай”[4] гэсэн нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын онолын үндсийг бий болгоход зохих ёсоор нөлөөлсөн байна.

Аюулгүй байдлын онол, үзэл баримтлал, арга зүйд томоохон өөрчлөлт гарч, аюулгүй байдлыг хангах үндсэн үйл ажиллагаа бол аюулгүй байдалд нөлөөлж буй аюулын чиг хандлагын судалгаа, дүн шинжилгээ юм. Энэ нь аюулгүй байдалд заналхийлж буй аюулын хэлбэрийн агуулга, шинж чанар өөрчлөгдөж, өргөжих, шинэ чиглэл рүү шилжиж буй зэрэг үйл явцыг ойлгож мэдэхийн тулд аюулгүй байдалд заналхийлж буй хэлбэрүүдийг олж тогтоох явдал ажгуу. Түүнчлэн аюулгүйжүүлэх (securitization) хэмээх шинэ ойлголт гарч ирэв.

2004 оны 12 дугаар сард «Илүү аюулгүй Дэлхий ертөнц: Хамтын хариуцлагыг хуваалцахуй» илтгэлийг авч хэлэлцээд хүн төрөлхтний ирээдүйд заналхийлж буй дараах 10 аюулыг нэрлэсэн байна.

Үүнд:

1. Ядуурал
2. Халдварт өвчин
3. Хүрээлэн буй орчны доройтол
4. Улс хоорондын дайн
5. Иргэний дайн
6. Төрлөөр устгах
7. Хүний наймаа
8. Үйл олноор хөнөөх зэвсгийн тархалт
9. Терроризм
10. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг

Аюулгүй байдал судлалын шинэ параметр:

Даяаршил, хүний аюулгүй байдал болон аюулгүйчүүлийг эмпирик судалгааны түвшинд:

[4] Л.И.Шершнев. Безопасность., №4, М. -1994, с. 13

Нэгд: Шинэ аюулгүй байдлын сорилтын тоо, тухайлбал терроризм, хүний эрүүл мэнд, амь насанд аюултай өвчний цар тахал, олон улсын цагаачлал, шилжилт хөдөлгөөн, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, эрчим хүчний аюулгүй байдал, цөмийн зэвсгийн тархалт, тэдгээрийн олон улсын аюулгүй байдлын системд үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ;

Хоёрт: БРИКС-ийн орнуудын сэргэн мандалт, олон улсын аюулгүй байдлын системд үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ, олон улсын харилцааны олон туйл глобал аюулгүй байдлын системийг тогтворгүй болгох магадлалтай өндөр болсоор байгаа;

Гуравт: *Д*айны үндсэн шинж чанарт өөрчлөлт гарч, ялангуяа иргэний дайны өргөжилт нь тодорхой нутаг дэвсгэр, улс доторх мужуу гадны оролцоотойгоор бие даах,тусгаар тогтнох чиг хандлагатай болж байгаа явдал юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ.

Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь Үндсэн хуулийн дараа орохуйц чухал ач холбогдолтой тул зөвлөл байгуулан үзэл баримтлалыг боловсруулах ажлыг эхлүүлж анх 1994 онд УИХ-аар батлуулсан. Энэ үзэл баримтлал нь түүхэн нэн эгзэгтэй үед үндэсний аюулгүй байдал, үндэсний эрх ашгийг хангах төрийн бодлогын үндсэн зарчим чиглэлүүдийг зааж өгсөн нь чухал үүрэг гүйцэтгэж, шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулж, тусгаар тогтнолоо баталгаажуулах, хөгжлийн суурийг тавихад чухал ач холбогдолтой байсан юм.

1994 онд батлагдсан Үзэл баримтлал ийнхүү түүхэн нэн чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд өдгөө манай улсын аюулгүй байдлын гадаад, дотоод нөхцөл байдал өөрчлөгдөж, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн шинэчлэх шаардлага бий болсон.

Энэ байдлыг үндэслэн 2009 оны 12 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар ажлын хэсэг байгуулагдан ҮАБЗ-ийн ажлын алба, төр, олон нийтийн байгууллагууд, иргэд, эрдэмтэн, судлаач, УИХ-ын гишүүдийн оролцоотойгоор үзэл баримтлалын төслийг боловсруулан батлуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар шинэчлэгдсэн Үзэл баримтлал нь шинэлэг зарчим, номлол дээр суурилсан, төрийн нэгдмэл бодлогын залгамж холбоо, уламжлалыг хадгалсан, 1994 оны Үзэл баримтлалын органик үргэлжлэл юм.

Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалыг 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдөр УИХ баталсан. Энэ үзэл баримтлал нь үндэсний аюулгүй байдлыг хангах гол чиглэл, арга замыг тодорхойлсон төрийн бодлогын чухал баримт бичиг бөгөөд үүнээс үүдэлтэй аюулгүй байдлын салбар, эрх зүйн орчны өргөн хүрээтэй шинэтгэлийг эхлүүлж байна.

Үндэсний аюулгүй байдал гэдгийг өмнө нь уламжлалт улс төр, цэрэг, дайны заналхийлэлтэй холбон ойлгож, зөвхөн төр, түүний тусгай байгууллагуудын үүрэг хэмээн үзэж байв. Шинэ нөхцөл байдал нь аюулгүй байдлын тухай ойлголт, цар хүрээ, хангах арга замыг өргөтгөж, шинэчилсэн үзэл баримтлал нь хүн төвтэй, цогц мэдлэгт суурилсан гэсэн суурь зарчмаар өөрчлөгдсөн.

Аюулгүй байдалд хандах хандлага, шийдвэрлэх арга замуудыг шинээр томьёолж оршин тогтнохуйн аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, хүний аюулгүй байдал, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал гэсэн 6 чиглэлээр цогц, консайленс хэлбэрээр харилцан уялдаатай хангах, нийгэм иргэдийн хамтын хүчээр хангах зарчим дээр тулгуурлах шаардлагатай болсон. Иймд төр үндсэн үүргээ гүйцэтгэхдээ иргэдтэйгээ хамтрах, санал, бодлыг нь сонсох, тэднийг шийдвэр гаргах, хяналт тавихад оролцох боломжоор хангах арга хэмжээг авна.

Хувь хүний аюулгүй, амгалан, эрүүл, хангалуун амьдрал нь нийгмийн тогтвортой байдал, хөгжил дэвшлийн сурвалж болж, энэ нь цаашлаад төр, улс, үндэсний аюулгүй байдлыг хангана. Мөн төр, нийгэм нь аюулгүй байж иргэдийнхээ аюулгүй байдлыг хангана гэсэн хүн төвтэй аюулгүй байдлын үзэл. Тиймээс хүний амар амгалан, аюулгүй, эрүүл, хангалуун амьдрах, түүний хөгжих, хөдөлмөрлөх нөхцөл бүрдсэн, орлого, хүрээлэх орчин, хүнс

нь аюулгүй байх цогц бодитой, оновчтой шийдлийг тусгасан мэдлэгт суурилсан үзэл баримтлал юм.

Үндэсний аюулгүй байдлыг хангах, үндэсний эрх ашиг, үнэт зүйлийг хамгаалах, хэвшүүлэх, улс орны хөгжлийг хангах, эв нэгдэл, нийгмийн оюун санааг төлөвшүүлэхэд чиглэгдсэн тодорхой зорилт, арга хэмжээг тусгаснаар тунхаглалын шинжтэй бус тар, нийгэм, иргэдийн харилцан хамтын ажиллагаагаар, харилцан уялдаатай хангах тодорхой стратеги, чиглэлийг заасан нь чухал ач холбогдолтой болсон.

2. Хорих байгууллагын аюулгүй байдал

ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БҮРЭЛДЭХҮҮН

Аюулгүй байдлын төрөл	**Тодорхойлолт**	**Аюул**
Эдийн засгийн аюулгүй байдал	Ажлын байр, орлогын баталгаатай байдал	Ядуурал, ажилгүйдэл, өрөнд баригдах, түүний төлбөрийн дарамт, орлогын хомсдол
Хүнсний аюулгүй байдал	Суурь хүнсний хүртээмж	Өлсгөлөн, хүнсний наад захын зүйлсийн хомсдол
Эрүүл мэндийн аюулгүй байдал	Өвчнөөс хамгаалагдсан байдал, эрүүл амьдралын хэвшил	Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжгүй, чанаргүй байдал, шинэ болон сэргээгдсэн өвчний цар тахал, тэжээлийн дутагдал, орчны бохирдол, амьдралын хэв шинжийн хамгаалалтгүй байдал
Хүрээлэн буй орчны аюулгүй байдал	Эрүүл орчин	Орчны ялзрал, байгалийн гамшиг, бохирдол, байгалийн нөөцийн шавхагдлаа сөрөг үр дагавар
Хувь хүний аюулгүй байдал	Биеийн хүчний хүчирхийлэл	Төрийн эрүү шүүлт, дайн, түгшүүр, зохион байгуулалттай гэмт хэрэг
Цөөнхийн аюулгүй байдал	Бүлэг, гишүүнчлэлийн хамгаалал	Үндэсний цөөнхийн хүчирхийлэл, угсаатан хороодын хурцадмал байдал
Улс төрийн аюулгүй байдал	Нийгэм дэх аж байдал, хүний эрх, эрх чөлөөний хамгаалал	Улс төр, төрийн хэлмэгдүүлэлт, эрүү шүүлт, аллага, мөрдөх цагдах, шоронд хорих, хүний эрхийн гажуудал

Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээ

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ДОТООД БОЛОН ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛС

Хэлбэр төрөл	**Нөлөөлж буй хүчин зүйлс**	**Эрсдэлийг бууруулах арга хэмжээ**
Гадаад	Байгалийн гамшиг (үер, гал түймэр, бороо, цас, шуурга, газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт)	Онцгой байдлын байгууллагаас явуулж буй гамшгийн эсрэг сургалтуудыг чанаржуулах, практикт хэрэгжүүлэх
	Эдийн засгийн хямрал	Эдийн засгийн зөв бодлого боловсруулан хэрэгжүүлэх
	Улс төрийн хямрал	Гадаад орчинтой харьцах харьцаа, мэдээ, мэдээллийн сувгуудыг хяналтад авах
	Орон тооны тогтворгүй байдал, ажлын халаа сэлгээ	Боловсон хүчний зөв бодлого боловсруулан хэрэгжүүлэх
	Хууль эрх зүйн хийдэл, хууль үйлчлэх хугацааны тогтворгүй байдал	Хуулийг даган гарч буй журмуудыг боловсронгуй болгох, хууль тогтоох эрх мэдлийн байгууллагыг сахилга баттай болгох
	Нийгмийн шилжилтийн үе	Нийгмийн шилжилтийн үед аюулгүй байдлыг хангах нь туйлын чухал асуудал юм. Соён гэгээрүүлэх ухамсарт нөлөөлөх арга хэрэгслийг сүвэгчлэх
	Ядуурал, ажилгүйдэл, нийгмийн эмх замбараагүй бадал	Эдийн засгийн зөв бодлого боловсруулан хэрэгжүүлэх, ухамсарлуулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх
	Гадаад улс орны цэргийн дайралт, түрэмгийлэл, хавчин гадуурхалт	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн түвшинд авч хэлэлцэж, зөв бодлогыг хэрэгжүүлэх
	Халдварт өвчин	Үндэсний болон байгууллагын түвшинд зөв бодлого боловсруулан ажиллах
Дотоод	Байгууллагын удирдлагын болон бусад алба хаагчдын буруутай шийдвэр	Гаргасан шийдвэр нь ямагт хууль, журамд нийцсэн байна. Алба хаагчдыг сурган дадлагажуулах ажлыг эрчимжүүлэх
	Байгууллагын дотоод журам, үйл ажиллагаа нь хуультай харшлах	Журам боловсруулж буй алба хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг сайжруулах, практик ажиллагаатай уялдуулах

	Хууль эрх зүйн уялдаагүй байдал	Журам боловсруулж буй алба хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг сайжруулах, практик ажиллагаатай уялдуулах
	Харуул хамгаалалтын доголдол	Харуул хамгаалалтын журмыг боловсронгуй болгох
	Боловсон хүчний дутагдал	Боловсон хүчний бодлогыг боловсронгуй болгох
	Алба хаагчдын мэдлэг ур чадвар сул	Давтан болон мэргэшүүлэх сургалтыг эрчимжүүлэх
	Техник хэрэгслийн хомсдол	Техник хэрэгслийн судалгааг жил бүр танилцуулж, төсөвт хөрөнгийг суулгуулах
	Халдварт өвчин	Халдварт өвчинтэй тэмцэх ажлын төлөвлөгөө боловсруулах
	Хоригдогсдын ухамсар сэтгэлгээний дорой байдал	Хоригдогсдыг нийгэмшүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх
	Байгууллагын бодлого шийдвэрийн буруу байдал	Хууль журамтай нийцүүлэн чадавхжуулах сургалтын бодлогыг эрчимжүүлэх


ДҮГНЭЛТ

Монгол Улсын иргэн бүр үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно. Үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн анхдагч үүрэг мөн. Иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэгтэй байх, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах, хамтран ажиллахад төр онцгой анхаарна.Монгол Улсын "оршин тогтнохуйн аюулгүй байдал", "эдийн засгийн аюулгүй байдал","дотоод аюулгүй байдал", "хүний аюулгүй байдал", "хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал","мэдээллийн аюулгүй байдал" харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна.Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг,мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна.Болзошгүй аюул, сорилтыг бодитой тодорхойлж, тэдгээрийг гэтлэн давахад хязгаарлагдмал нөөц, боломжийг үр дүнтэй дайчилна. Даяаршил улс үндэстний бусдаас хамаарах эмзэг байдлыг нэмэгдүүлж, нөгөө талаас

гадаад нөөц боломжийг ашиглан үндэсний ашиг сонирхлоо хамгаалж бататгах боломж олгож байна.

МОНГОЛ УЛСЫН 2019, 2020 ОНЫ ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

/Үндэсний статистикийн хорооны 2019, 2020 оны судалгаа/



Хүнсний хангамжийг тооцохдоо нөөцийг жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээнд харьцуулж, 100-аар үржүүлэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн дагуу гаргана.

Үүнийг томьёогоор харуулбал: ХХхувь = Нө *100 ЖХжиш ЖХжиш - Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ Нө - Нөөц ХХхувь - Хүнсний хангамжийн хувь

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. “Эдийн засгийн аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудал” УБ, 2020 он Д.Тунгалаг
2. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” 2010 он
3. “Аюулгүй байдлын орчин үеийн үзэл баримтлалын шинэ чиг хандлагын дүн шинжилгээ” 2019 он Д.Уламбаяр
4. Ч.Улаанхүү . “Аюулгүй байдлын үндэс”. УБ., 2016. 13-21 дэх тал
5. В.И.Ярочкин. Секьюритология, “Ось-89”. 2000., с. 25
6. Л.И.Шершнев. Безопасность., №4, М. -1994, с. 13
7. А.Карпов. Становление науки о безопасности. Безопасность, № 10-12, М.-1997

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Д.МӨНХЦЭЦЭГ

Товч агуулга: Аливаа улс оронд төрт ёс үүсэн бий болж, хөгжин ирсэн түүхэн замнал нь үе үеийн хууль сахиулах чиг үүрэг бүхий тусгайлан оногдуулсан үүрэг хүлээсэн хүмүүс /цагдаа, цэрэг, хуяг/-тэй салшгүй холбоотой бөгөөд ажиллах хүн хүчний нөхөн бүрдүүлэлт, хууль эрх зүйн зохицуулалт бол гол зүйл юм.

Тэднийг идэвх, зүтгэл, үр бүтээлтэй ажиллуулах, ажилдаа хандах хандлагыг судлах, хэрхэн сонгон шалгаруулж ажиллуулах нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад тулгамдаж буй асуудлуудын нэг байсаар ирсэн.


Abstract: The history of the establishment and development of statehood in any country is inextricably linked with the generation of law enforcement officers (police, soldiers, bodyguards), and the retraining and legal regulation of the workforce thing.

One of the challenges for the Judiciary is to keep them active, diligent and productive, to study their attitudes and how to select them.


Түлхүүр үгс: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, бие бүрэлдэхүүн, хүний нөөц, ажиллах хүч, сонгон шалгаруулалт, манлайлал, жендэр

Keywords: General Executive Agency of Court Decision, personnel, human resources, workforce, selection, leadership, gender

1. Байгууллагын хүний нөөцийн бодлогод жендэрийн асуудлыг тусган, үр дүнтэй хэрэгжүүлэх нь



Байгууллага дахь жендэрийн тэгш байдал



✓ Байгууллагын бодлого, үйл ажиллагааг хүн төвтэй болгох боломж,

✓ Үйл ажиллагаагаа илүү оновчтой, үр дүнтэй болгох, нөөц (хүний, цаг хугацааны, санхүүгийн) хэмнэх боломж,

✓ Байгууллагын соёлыг дээшлүүлэх, хөгжүүлэх боломж



Байгууллагад ажиллаж буй нас, хүйс, гарал угсаа, хэл соёл, шашин шүтлэг бие махбодийн хувьд ялгаатай хүмүүсийг үл гадуурхсан, үл ялгаварласан уур амьсгал, хандлага, харилцааг, тэдний хэрэгцээнд нийцсэн ажлын орчныг бий болгох буюу хүмүүсийн олон янз байдлыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэх зарчимд тулгуурласан байх ёстой.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлт, бүрдүүлэлтийн эх үүсвэрүүд ба аргууд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлт:

Бүрдүүлэлт гэдэг нь шаардлагатай тоо, чанарыг хангах чадварлаг ажил горилогчдыг олж цуглуулах, ингэснээр байгууллагын хувьд тухайн ажлын байранд хамгийн сайн тохирох хүмүүсийг шилж сонгох боломжийг олгох нягт нарийн үйл ажиллагаа гэж ойлгодог.

Нөгөө талаас байгууллагын шаардлагад нийцэхүйц боловсрол мэдлэг чадвартай хүнийг олох явдал юм.



Бүрдүүлэлтийн эх үүсвэрүүд ба аргууд


Дотоод арга зам:


1. Аж ахуйн нэгж дотроо зарлал гаргах,
2. Өөр ажилд шилжүүлэх,

3. Хүний нөөцийг хөгжүүлэх,
4. Хавсарган ажиллуулах.

Гадаад арга зам:

1. Хөдөлмөр зуучлалын албаар дамжуулах,
2. Ажлын байр /сонин, хэвлэлээр/-ыг зарлах,
3. Зар сурталчилгаа,
4. Интернэт,
5. Чадварлаг хүний нөөцөөё шууд сурталчилгааны аргаар элсүүлэх,
6. Зохион байгуулалтын арга хэмжээ,
7. Түр хугацааны ажил,
8. Хүний нөөцийн зөвлөхийн тусламжтайгаар сонгох





3. Бүрдүүлэлт ба бусад үйл ажиллагаануудын харилцан холбоо, үнэлэх нь

-Хүний нөөцийн төлөвлөлт,

-Ажлын шинжилгээ,

-Сургалт ба хөгжил.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд:

-Үндсэн ажилтнууд,

-Гэрээт ажиллагсад,

-Ажилд орох хүсэлт гаргасан ажил сонирхогчид,

-Нөөцөнд байгаа ажилтнууд болон иргэдээс бүрддэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн оновчтой сонгон шалгаруулалтын үед чадварлаг нөөцийн хомсдол, хуурамч талентууд, алдаатай сонгон шалгаруулалт, ажилтны чадавхийн асуудал, байгууллагын нэр хүнд зэрэг хүндрэл гардаг бөгөөд монгол хүний сэтгэлгээ, ажилд хандах хандлагын талаар судалгаанаас харахад хэт хялбарчлах /аливаад хөнгөн хандах/, хувийн зохион байгуулалтгүй, мэдрэмжгүй, цалин хөлсийг голдог зэрэг байдал ажиглагдаж байна.



Шагнал, урамшууллын тогтолцоо: Дотоод /Reward systems/ болон гадаад /Extrinsic reward/ гэж урамшууллын төрөлтэй байдаг бөгөөд бүх шатны удирдлага өөрийн удирдлаган доорх ажилтнуудаа урамшуулах, тэдний хувь нэмрийг цаг алдалгүй үнэлэх зорилготой байдаг.

Шагнал урамшууллын зөв бодлогын үр дүнд чадварлаг мэргэшсэн ажилтнуудыг ажилд авах, тогтоон барих үндсэн нөхцөл, ажилтнуудын ажиллах урам зориг, хүсэл эрмэлзлийг бий болгох гол хөшүүрэг болдог мөн байгууллагын зорилгод хүрэхэд түлхэц үзүүлдэг байна.

Дээрхээс гадна ажиллах сонирхолтой хүмүүсийн сонголтын хүрээ нэмэгдэж, байгууллагын доторх өрсөлдөөнт, бүтээлч уур амьсгал, өөрийгөө дайчлах хүсэл сонирхол бүрддэгийг дурдах хэрэгтэй.

ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулиар хүлээсэн чиг үүрэг, стратеги зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, хүний нөөцийн төлөвлөлт, зохион байгуулалтыг боловсронгуй болгоход гол анхаарлаа чиглүүлэн ажилласаар ирсэн.

Мөн чиг үүргийн дагуу алба хаагчдыг ажилд нь дадлагажуулах, тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч тодорхой арга хэмжээ зохион

байгуулдагч хэдий ч сүүлийн 09 дүгээр сарын байдлаар 165 алба хаагч албан тушаалаас чөлөөлөгдсөн бөгөөд шалтгаан нөхцөлийг судлахад удирдах албан тушаалтны дарамт шахалт, зүй бус харьцаа, ажлын ачаалал, орчин нөхцөлөөс шалтгаалж гарах тохиолдол эзэлсэн байна.

Санал:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “*ШШГБ-ын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив*”-д заасны дагуу хүний нөөцийн нөхөн хангалтыг хийж, нөөцийг хангалттай түвшинд бүрдүүлж, алба хаагчдын ажлын ачааллыг бууруулах, илүү цагаар ажиллуулахгүй байх, ингэснээр алба хаагчдын ажлын ачаалал буурч гэр бүлдээ зарцуулах цаг нэмэгдэж улмаар ажилдаа хандах хандлага нь сайжирна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сургалт ба хөгжлийн тогтолцоог бий болгох буюу хөгжүүлэх, байгууллагын онцлог, үйл ажиллагааг сайтар таниулах. Алба хаагчдыг сурган дадлагажуулах сургалтыг тогтмол зохион байгуулснаар нэгт ажлаас гарах эрсдлээс сэргийлэх, хоёрт хөгжүүлэх давуу талыг бий болгохын зэрэгцээ сургалтын хэрэгцээ нь байгууллагад шинээр хүн ажилд орох, ажилтныг шинэ ажил, албан тушаалд томилох, ажлын ур чадвар бүтээмж нэмэгдүүлэх, ажлын мэдлэг, ур чадвар дутагдах зэрэг шалтгааныг арилгах чухал ач холбогдолтой.

3. Байгууллагын эрхэм зорилго, зорилт, байгууллагын онцлог, чиг үүргийн хүрээнд ажилтан эсвэл хамт олны ажлын үр дүнг болон аливаа амжилтыг цаг алдалгүй үнэлэн бусдад үлгэрлэн таниулах зорилгоор шагнаж урамшуулах. Алба хаагчдыг сайшааж талархах, байгууллагын болон бусад шагналаар шагнаж урамшуулахад үнэлгээ шударга ил тод, цаг үеэ олсон, мэдэгдэхүйц, ач холбогдол бүхий, тооны хязгаар тавьж болохгүй ба материаллаг болон сэтгэл санааны урамшууллыг хослуулсан байвал үр дүнтэй.

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ХЯНАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

М.ДАВААБАТ

Товч агуулга: Өгүүлэлд зарим улс орнуудын пенитенциар байгууллагуудын үйл ажиллагааг судалсан. Өндөр хөгжилтэй орнуудад пенитенциар байгууллагад хяналтын зохион байгуулалтын тал дээр өргөн, олон талт, маш их туршлага байгааг тэмдэглэх нь зүйтэй. Эдгээр орнуудад хорих байгууллагад хяналтыг зохион байгуулахдаа шинэлэг техник хэрэгслийг ашигладаг байна.

Олон улсын туршлагыг судалснаар Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх тогтолцоонд хяналтын зохион байгуулалтын талаар шинэ арга хэлбэрийг нэвтрүүлэх, эрх зүйн баримт бичигт тодотгол хийх, зарим тохиолдолд ирээдүйд гарах алдаанаас урьдчилан сэргийлэх боломжийг өгдөг байна.

Abstract:

Түлхүүр үг: пенитенциар байгууллагууд, дэглэм, хяналт, хоригдол, үзлэг, нэгжлэг.

Keywords: legal status, convicts, prisoners, armored delivery, vehicle, prisons

Өөрийн улс, орны эрүүгийн ял эдлүүлэх тогтолцоог сайжруулахад гадаадын тэргүүлэгч орнуудын пенитенциар байгууллагуудын үйл ажиллагааг өргөнөөр судлах хэрэгтэйг багагүй судлаачид онцлон тэмдэглэсэн байдаг. Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны талаар бүтээлүүдийг судлан үзэхэд Их Британи, ХБНГУ, Франц, Испани, АНУ, Швед, Япон улсууд нь өөр өөр пенитенциар тогтолцоотой бөгөөд хоригдлуудад хяналт тавих нь ч үүнийгээ дагаад адилгүй байсан. Мэдээж энэ нь эдгээр орнуудын эрүүгийн, эрүүгийн ял эдлүүлэх бодлого, гэмт хэргийн нөхцөл байдал, нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд, техникийн хангамж болон бусад хүчин зүйлүүдтэй шууд холбоотой юм.

Үүнтэй зэрэгцэн өөрийн үндэсний эрх зүйн онцлогоос хамааран хорих байгууллагууд, хоригдлуудыг ангилах талаар нэгдсэн үзэл санаа ч байдаг.

Олон улсын туршлагыг судлах нь Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх тогтолцоонд хяналтын зохион байгуулалтын шинэ арга, хэлбэрийг нэвтрүүлэх, гадаадын орнуудын хорих байгууллагуудын гаргасан алдаанаас урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлнэ.

НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүдийн ...

Хөгжингүй орнуудад хяналт тавих асуудлыг боловсронгуй болгох замаар биелүүлж байна. Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх тогтолцоонд хорих ял шийтгүүлсэн өсвөр насны болон эмэгтэй, эрэгтэй хоригдлыг тусад нь, бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй хоригдлыг бусад хоригдлоос тусгаарлан, анх удаа ял эдэлж байгаа хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, засарч хүмүүжиж байгаа хоригдлыг засарч, хүмүүжихгүй байгаа хоригдлоос, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн болон зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнд тооцогдож ял шийтгүүлсэн хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ гэсэн зарчим байдаг. Гадаадын орнуудад хяналтыг зохион байгуулахдаа шинэлэг техник хэрэгслийг ашигладаг байна. Жишээ нь Их Британид техникийн хангамжийн хувьд хамгийн дэвшилтэд хорих ял эдлүүлэх байгууллагаар дараах байгууллагыг хэлж болом юм. Үүнд:

1. Боттоны шорон, энд хоригдож байгаа хүмүүсийн дийлэнх нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгг үйлдсэн этгээдүүд байдаг байна. Тэдэнд хяналт тавихдаа тусгай цахим техник хэрэгслийг ашигладаг.
2. Стайлын эмэгтэйчүүдийн шорон. Энэ шоронд зэвсэглэсэн хамгаалалтын ажилтан байхгүй. Хяналтыг техник хэрэгсэл ашиглан тавьдаг. Жишээ нь шоронгийн эргэн тойрны бүснийн хяналтыг камерын тусламжтайгаар харуул хамгаалалтын алба хаагчид зохион байгуулдаг. Амьдралын бүс, хоригдлын өрөө, салхилах газар, үйлдвэрийн хэсэгт ч мөн адил камерын хяналтыг тавьдаг байна.
3. Манчестерын шорон нь нэгдсэн төвийн удирдлагын хэсэгтэй бөгөөд хорих байгууллагаас оргохоос урьдчилан сэргийлэх, хоригдлуудын үйл хөдлөлд камерын хяналтыг тавьдаг.

Швед Улсын Стокгольм хотоос холгүй орших Кумла гэх хорих байгууллагыг судлан авч үзье. Хяналтын цамхаг байдаггүйгээрээ энэхүү хорих байгууллага нь онцлогтой. Хэрмэн хашааг төмөр тортой бөгөөд хяналтын камер, хөдөлгөөн мэдрэгчийг суурьлуулсан байдаг. Хөдөлгөөн мэдрэгчид ойртох оролдлого хийхэд л тусгай дохио ажиллаж эхэлдэг байна. Бүхий л хэсэгт камерын хяналттай, тэр дундаа гал тогоо, спорт заал, үйлдвэрлэлийн хэсэг зэрэг. Хорих байгууллагын бүх байгууламжид камерын хяналт заавал байх ёстой бөгөөд хяналт тавих, хүний эрхийг хангах зорилготой байна. Нэг талаасаа, өөрсдийн камераас (өрөө) гадна байхдаа хоригдлууд байнгын хяналтад байдаг, нөгөө талаас тогтмол бичлэг хийгдэж байдгаас хамгаалалтын ажилтнууд өөрсдийгөө зөв авч явах шаардлагатай болдог байна. Аюултай гэмт хэрэгтнүүдийг хорих, дэглэмийг хүндрүүлэх зорилгоор Шведийн гурван хорих байгууллагын хэсэгт “бункер”-ыг барьсан бөгөөд өөрөөр хэлбэл тэндээс оргох ямар ч боломжгүй юм. Бункер-шоронгуудад хамгаалалтын ажилчидтай шууд харьцах боломжгүй бөгөөд өөр хоорондоо заримдаа л харьцдаг байна. Богино хугацааны салхилалтыг хаалттай хэсэгт зохион байгуулдаг бөгөөд бүх хөдөлгөөнийг газар доогуур хийж техник хэрэгслийн тусламжтайгаар тогтмол хяналтыг тавьдаг.

Америкийн Нэгдсэн Улсад хуульд заасны дагуу цахилгаанжуулсан хязгаарлалтын хашааг өргөнөөр ашигладаг. АНУ-ын харуул хамгаалалтын чиг үүрэг бүхий шоронгийн алба хаагчид галт болон химийн (нулимас асгаруулагч), бороохой, номхруулагч цамц болон бусад техник, хэрэгсэл ашиглах боломжтой байдаг. Тэдэнд зориулан хоригдлуудтай харьцахдаа дагаж мөрдөх зан байдал, зан үйлийн заавар боловсруулагдсан байдаг бөгөөд тус баримт бичигт зөвхөн эрх зүйн бус өөрийгөө хамгаалах сэтгэл зүйн онцлог, биеийн хүч ашиглах зэргийг тусгасан байна. Хамгийн чухал нь алба хаагчдын зүгээс хоригдолд хэрэглэж байгаа санкци нь тэдний гаргасан хууль бус үйлдэлд оногдуулах арга хэмжээнд таарсан байх ёстой юм.

Гадаадын улс, орнуудын хорих байгууллагуудад үзлэг, нэгжлэгийг хэрхэн явуулдаг, тэдгээрийн онцлогийг мөн судлах нь зүйтэй. Жишээ нь, Их Британид шоронруу нэвтрэхийн тулд алба хаагч, иргэн, хашиж байгаа албан тушаал, нийгмийн байдлаас үл хамааран нэгжлэг хийлгэх ёстой.

Эдгээр арга хэмжээнүүд нь хууль бус үйлдэл гарах магадлалыг эрс бууруулж, тухайлбал хориотой эд зүйлсийг шоронд нэвтрүүлэх боломжийг

бууруулж, эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн ажилчдад үзүүлэх дарамтыг бууруулдаг. Дээр дурдсан Боттоны шоронгийн аюулгүй байдлын хэлтэс сард дор хаяж хоёр удаа хорих байгууллагын байгууламжид нарийвчилсан шалгалт хийдэг. Орой, шөнийн цагаар ч хамаагүй ямар ч хоригдолд нэгжлэг хийх боломжтой. Стайлын шоронд бараг бүх эмэгтэй хоригдлын биед үзлэг хийх боломжтой байдаг бөгөөд үүнийг эсрэг хүйсийн төлөөлөгч хийж болдог онцлогтой. Их Британийн шоронд зөвхөн Хатан хаан, Ерөнхий сайд нарт үзлэг, нэгжлэг хийх боломжгүй. Бусад хүмүүс, тэр байтугай хатан хааны ойр дотны хүмүүсийг оролцуулаад өндөр албан тушаалтнуудад хүртэл өдөрт хэд хэдэн удаа үзлэг, нэгжлэг хийж болно.

Францын ихэнх шоронд хяналтыг зохион байгуулахдаа хоригдлуудыг ангилан ялгах зарчимд суурилдаг. Энэ зорилгоор янз бүрийн хөтөлбөр боловсруулагддаг байна. Жишээлбэл, гэмт хэрэгтнүүдийг тодорхой онцлогоор нь хянах систем бөгөөд энэ нь тусгайлан бэлтгэсэн тест ашиглан, схемийн дагуу судалгаа хийж ангилдаг юм.

Хоригдол бүрийн хувьд дараахь шинж тэмдгүүдийг тусгасан тусгай картуудыг боловсруулсан: сэтгэл гутралын байдал байгаа эсэх; илрэл, хэт их түгшүүр, түрэмгий байдал; ичиж зовох эсвэл хэт ичимхий байдал; зан байдал, ярианд ер бусын зүйл байгаа эсэх; архи, мансууруулах бодисын нөлөөн дор байгаа зэрэг. Хоригдлуудад 24 цагийн турш хяналт тавих нь аюулгүй байдлын заавал биелүүлэх шаардлага гэж үздэг бөгөөд шоронгийн байцаагч хяналт тавьдаг. Хорих ангийн нутаг дэвсгэр дээр хоригдлуудын амь нас, аюулгүй байдалд заналхийлэх нөхцөл байдал үүссэн тохиолдолд алба хаагчид сонсогдохуйц газар байх, эсвэл дуудлага хийх хэрэгсэлтэй байх ёстой. Хоригдол бүрийг цагт нэгээс доошгүй удаа хяналт тавьж байх ёстой. Энэхүү шаардлагыг телесистемийн тусламжтайгаар гүйцэтгэдэг. Бидний бодлоор Испанид хорих ял сонссон хүмүүсийг хянах туршлага нь онцлогтой юм. Хоригдлуудыг GPS хяналтын цахим бугуйвч, цусан дахь спиртийн агууламжийн үзүүлэлтийн төхөөрөмж, хувийн дуу хоолой таних төхөөрөмж ашиглан хяналт тавих үр дүнтэй хамгаалалтын системийг бий болсон. Дээр дурдсан зүйлийг дүгнэж хэлэхэд гадаадын улс орнуудын хорих ангиудад хяналтын зохион байгуулах талаархи баялаг, олон янзын туршлагыг тэмдэглэх шаардлагатай байна. Хорих байгууллагуудын дэглэмийн шаардлага нь удирдлага, зохицуулалтын хатуу тогтолцоотой байдаг онцлогтой. Хоригдлуудын хувийн шинж чанар, хандлага, онцлогийг харгалзан хяналтыг ялгаатай байдлаар явуулдаг. Шоронгийн алба хаагчид

аюулгүй байдлын үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх маш өргөн хүрээний техник хэрэгсэлүүдтэй байдаг байна. Ийм төрлийн сайн туршлагыг Монгол Улсын эрүүгийн ял, эрүүгийн ял эдлүүлэх тогтолцоонд амжилттай ашиглаж болно. Орчин үеийн нөхцөлд техникийн хэрэгслийг идэвхтэй нэвтрүүлснээр хоригдлууд хорих байгууллагаас оргон зайлах магадлалыг бууруулахаас гадна алба хаагчдын ажлыг ачааллыг бууруулах боломжтой. Гэсэн хэдий ч бүх зүйлийг гадаадын туршлагаас суралцах ёсгүй. Бидний бодлоор нэр төр, алдар хүндийг хамгаалах зарчмыг баримтлах шаардлагатай байна. Тиймээс, бидний бодлоор хоригдлуудын биед үзлэг хийх туршлагыг туршиж үзэх нь зохимжгүй бөгөөд үүний том жишээ нь Английн Стиллийн эмэгтэйчүүдийн шоронд хэрэгжүүлдэг хоригдлуудын биед эсрэг хүйсийн алба хаагч үзлэг хийж болдог байна.

Гадаадын зарим орны шоронд (жишээлбэл, Швед Улсад) алба хаагчид болон хоригдлуудын тооны харьцаа бараг 1:1 -ийн харьцаатай байдаг бөгөөд Монгол Улсын хорих ял эдлүүлэх байгууллагуудад ээлжийн харуул хамгаалалтын ажилтны харьцаа 100 хоригдолд 2-3 алба хаагч байгаа юм.

Иймд, Монгол Улсын хорих байгууллагуудад дэг журмыг хангахын тулд гадаадын орнуудын чиг үүрэг адил байгууллагуудын сайн туршлага, ялангуяа хяналт, хяналтын техникийн хэрэгслийг ашиглах талаар судлах, цаашлаад нэвтрүүлэх нь зүйтэй гэж бид үзэж байна.

Энэ нь хорих ял эдлүүлэх дэглэмийг зөрчсөн буруутнуудыг цаг тухайд нь олж тогтоож, хариуцлага хүлээлгэхээс гадна эхний шатанд аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломжтой болно. Түүнчлэн, хорих ангийн нутаг дэвсгэрт нэвтэрсэн албан тушаалаас үл хамааран бүх хүмүүсийн техникийн хэрэгслийг ашиглан үзлэг, нэгжлэг хийх нь зүйтэй юм. Энэ нь хорих байгууллагад хориотой эд зүйл, ялангуяа гар утсыг нэвтрүүлэхийг багасгах, алба хаагчдын дунд гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлэх юм.

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

Г.БАЛЖМАА
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын
хүрээлэнгийн судлаач, докторант, ахлах дэслэгч

Товч агуулга:
Түлхүүр үг:

Abstract:
Key words:

Монгол Улсын Хорих ял эдлүүлэх ажиллагаанд “нийгмийн ажил”, “нийгэмшүүлэх” гэсэн нэр томьёо, ойлголт 2017 онд шинээр бие болсон хэдий ч хорих байгууллагын үйл ажиллагаанд энэ төрлийн арга хэмжээ хэрэгжиж эхэлснээс хойш даруй 20 жил болсон байна.

Илтгэлийн сэдвийн хүрээнд нийгэмшүүлэх ажлын түүхэн уламжлалын асуудлыг дэлгэрэнгүй хөндөх зорилт тавиагүй болно. Гэсэн хэдий ч товч дурдахад хоригдлыг нийгэмшүүлэх асуудал нь хорих ангийн ял эдлүүлэх ажиллагаатай шууд хамаарах тул эрх зүйн зохицуулалт, зорилгоор нь харьцуулбал:

1920-1940 он хүртэл ардын хувьсгалын болон дараах үеийн хорих ял эдлүүлэх ажиллагаа нь “Хэрэгтэн, ялтныг засан хүмүүжүүлэхэд хоригдогсдын биеийг элдвээр зовоох, доромжлох, жанчих, гар хөлийг хүлэх, харанхүй газар хорих, хоол ундыг хасах, ганцаар хорьж хэрхэвч болохгүй” гэсэн зорилготой байсан бол нийгэмшүүлэх ажлын чиглэлээр *“Хэрэгтэн хүнийг шийтгэх ял, улс төрийн бодлого бол хэрэгтнийг сурган хүмүүжүүлэхийг гол болгох, оногдуулах ял нь хууль зүйд нийцсэн, хэрэгтэн этгээдийг засрах бололцоо олгосон хөдөлмөр хийлгэх, цаг хугацаа дуусахын өмнө тэнсэн суллах зэргийг оролцуулсан байвал зохино”* гэсэн заалт[1],

[1] Б.Алтангэрэл, М.Хүрэлбат нар. Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн дүн шинжилгээ. УБ.,2020. 63 дахь тал

1940-1970 он хүртэл БНМАУ-ын социалист нийгмийн томоохон өөрчлөлт гарч хорих ял эдлүүлэх ажиллагаанд гяндан гэх ойлголт шинээр бий болон хуульчлагдаж “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ялыг хууль ёсоор эдлүүлж, тэднийг хууль ёсыг хүндэтгэн сахиж, социалист нийгмийн амьдрал, хөдөлмөрт хэвшүүлэн дахин хүмүүжүүлэх, тэднээс гэмт хэрэг үйлдэх буюу нийгэмд хортойгоор нөлөөлөх явдлаас урьдчилан сэргийлэхэд оршино” гэсэн зорилготой байсан бол нийгэмшүүлэх ажлын чиглэлээр *“Ялтан нарт лекц хэмээн сайн суртал журам, одоо цагийн улс төрийн шинэ хуучин байдал зэргийг ялган салгаж тодорхойлон хэлж ухуулахуйд олон сургуулийн багш, оюутан, сургуулийн шавь нар мэтийн эрдэмтнийг урин ирүүлж ухуулан гэгээрүүлбээс тустай бөгөөд одоо гяндагийн газар байшин савгүй тул энэ лекцийг өдрийн дулаан сайныг үзэж сар бүр хоёр удаа гяндангийн хашаан дотор ухуулан уншуулж, сэнхрүүлэн хэрэглэвээс зохино”*[2],

1970-1990 он хүртэл БНМАУ-ын социалист нийгмийн үргэлжлэл үед хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээнд “дахин хүмүүжүүлэх” гэсэн ойлголт шинээр бий болж “Ялтныг үйлдсэн гэмт хэрэг нь цээрлүүлэх төдийгүй, хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд биелүүлдэг, хамтын аж байдлын социалист хэв журмыг хүндэтгэдэг үзэлтэй болгон засан хүмүүжүүлэх, ялтныг болон бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн ял эдлэлтийн биелэлтийг хангах, түүнчлэн гэмт хэргийг арилгахад тус дөхөм үзүүлэх явдалд оршино” гэсэн зорилготой байсан бол нийгэмшүүлэх ажлыг “ахуй дэглэмийн байцаагч”- гэсэн орон тоон дээр *“Хоригдогсдыг эрхбиш аливаа боловсролын ажилд оролцуулан сургаж, тэдгээрээс алсдаа ажлын дадлагыг олж, суллагдан гарсны дараа ард олонд тустай ажил үйлдвэр хийж, гэмт явдлыг үйлдэх хэв заншлаа устгахад дөхөм болгохыг хичээнэ”,*

“Аливаа засан сайжруулах газар нь хоригдогсдыг сурган гэгээрүүлэх, боловсруулах ажлыг гүйцэтгэвэл зохимой”,

“Сурган гэгээрүүлэх явдлыг удирдах этгээд нь тусгай эрхлэгч байхгүй ахул уул газрын эрх баригчдын тушаалаар хоригдосдын дотроос чадамгай бөгөөд бичиг үсэг сайн мэдэх ба улс төрийн талаар итгэмжтэйгий нь тусгай томилж гүйцэтгүүлнэ. Тусгай эрхлэгчдээс тухайн ажлыг зүй

[2] Б.Алтангэрэл, М.Хүрэлбат нар. Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн дүн шинжилгээ. УБ.,2020. 67 дахь тал

зохистойгоор явуулах эцсийн үүргийг хүлээхээс гадна Ардыг гэгээрүүлэх яамны ерөнхий удирдлагыг бариимтлавал зохино”

“Ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх, түүнчлэн хорих нутаг зааж суулгах, уг нутгаас зайлуулах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн таслан шийтгэх тогтоолыг биелүүлж байгаа байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавихад олон нийт оролцоно. Ялтныг хүмүүжүүлэхэд олон нийтийн оролцох хэлбэр, журмыг энэ хууль болон бусад хууль тогтоомжоор тогтооно” гэх мэт арван гурван зүйл заалт бүхий хэм хэмжээ,

1990-2002 он хүртэл ардчилсан хувьсгалын үед хорих ял эдлүүлэх ажиллагааны зорилгод хүний эрхийн тухай ойлголт, хэм хэмжээ бий болж “Гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдсон этгээдийг нийтээс тусгаарлаж, эрх эрх чөлөөнд нь хуульд заасан хязгаарлалт тогтоож хууль дээдлэх, хүний эрх эрх чөлөөг хүндэтгэж, хорих ялыг ялгамжтай нөхцөлд эдлүүлэхэд оршино” гэж тусгагдсан бол нийгэмшүүлэх чиглэлээр *“Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон бусад хэлбэрээр зохион байгуулна”,*

“Хорих анги нь өөрийн эрхэлж байгаа үйлдвэрийн чиглэлээр хоригдолд хөдөлмөрийн дадлага олгох сургалт зохион байгуулж болно. Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хоригдлын сайн дурын үндсэн дээр хамруулна” гэх мэт гучин дөрвөн зүйл заалт,

2002-2017 он хүртэл эрх зүйн шинэтгэлийн хүрээнд “Хорих ял эдлүүлэх ажиллагааг олон улсын жишигт нийцсэн нөхцөлд хүргэх нь хорих байр, орчин, нөхцөлийг бусад оронтой жиших асуудлаар хязгаарлагдахгүй бөгөөд орон улсын гэрээ, конвенцийн хэм хэмжээ, үзэл баримтлалыг үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэх, ялын зорилго, нийгэмшүүлэх ажиллагааг бүрэн хангахад чиглэсэн эрх зүйн зохицуулалт, орчин нөхцөлтэй байхад оршино” [3] гэсэн зорилгын хүрээнд хоригдлыг нийгэмшүүлэх, тэдгээрт тулгарсан бэрхшээлийг даван туулахад туслах чиг үүрэг бүхий “Нийгмийн ажилтан”-ны орон тоо батлагдаж, 2006 оноос “Сэтгэл зүйчийн орон тоог бий болгосноор одоогийн хорих байгууллагын “Нийгмийн ажилтан-сэтгэлзүйч” гэсэн нэр томьёо гарч ирсэн. 2008 онд

[3] Б.Алтангэрэл, Ч.Мөнх-Эрдэнэ нар. Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ 2003-2018.УБ., 2019 он. 27 дахь тал

ШШГЕГ-т “Сургалт, нийгмийн ажлын тасгийг бий болгож, 2010 онд “Ялтны сургалт, хүмүүжлийн хэлтэс”, 2012 оноос “Нийгэм сэтгэл зүйн хэлтэс” нэртэйгээр өргөтгөн зохион байгуулан үйл ажиллагаа явуулж байна. Тус хуульд хорих байгууллагын чиг үүрэгтэй холбогдуулан *“Хүмүүжлийн ажлын хэлбэр, зохион байгуулалт”, “Хорих анги дахь сургалт”, “Ятныг суллах журам”* зэрэг шинээр заалтууд оруулсан байна

2017 оноос хойших үеийн хорих ял эдлүүлэх ажиллагаанд зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүд орж нийгэмшүүлэх ажлын төрөлд шинээр сэтгэл судлалын үйлчилгээ нэмэгдэхээс гадна хорих ял эдлүүлэх төрөл, дэглэм зэрэглэлийг шинээр тогтоон нээлттэй хаалттай хорих анги, энгийн ба тусгай зэрэглэл, хоригдлыг нийгэмшүүлэх болон аюулгүй байдлыг хангахтай холбоотой болон бусад асуудлыг шинээр хуульчилж өгч мөн тус хуульд нийцүүлэн ШШГЕГ-ын даргын “Нийгмийн ажлын аргачилсан заавар”, “Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн сэтгэл зүйн ажлын заавар”-ыг тус тус батлуулан үйл ажиллагаандаа даган мөрдөж байна.

Хорих байгууллагын нийгмийн ажилтан болон нийгмийн ахлах ажилтан нь хоригдлыг хорих анги, байгууллагад хүлээн авмагц нийгэмшүүлэх ажлын чиглэлээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, суллагдан гараад нийгмийн харилцаанд ухамсартайгаар оролцоход нь дэмжлэг үзүүлэх, хорих анги байгууллагын онцлогт тулгуурлан нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх замаар хоригдлыг нийгмийн ажлын үйлчилгээнд тасралтгүй хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангах чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг[4].

Өнөөгийн хорих ангийн нийгэмшүүлэх ажил хангалтгүй “Хорих ангиудын нийгэмшүүлэх ажлын заавар”-ын биелэлт 55-75 орчим хувьтай байгаа нь анхаарал татаж, биелэгдэх боломжгүй, уялдаагүй заавар байв уу, эсвэл хорих ангийн зохион байгуулалт, үйл ажиллагаандаа байна уу гэдгийг анхаарах шаардлагатай байгааг тус салбарын удирдлага, эрдэмтэн судлаач нар эрдэм шинжилгээний илтгэлд дурьдах болсон байна.

[4] Б.Алтангэрэл. Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажлын өнөөгийн байдал, чиг хандлага.-// “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэл” ЭШХ-ын эмхтгэл. УБ.,2021.т.89

Түүнээс гадна өнөөгийн хорих байгууллага дахь нийгэмшүүлэх ажлын үр нөлөө хангалтгүй байгааг давтан гэмт хэрэг үйлдсэн хорих ял эдлэгсдийн тоон судалгаанаас харж болохоор байна.

Тухайлбал: 2017 онд 1289 буюу 9.8%, 2018 онд 1614 буюу 45,7%, 2019 онд 1910 буюу 48.5%, 2020 онд ..... тус тус давтан ял эдэлсэн байна.[5]

2017-2020 оны жилийн эцсийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиудад 2017 онд -2942, 2018 онд-3525, 2019 онд-3751, 2020 онд-4372 хоригдол ял эдэлсэн бол мөн энэ хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 2017 онд-58, 2018 онд-58, 2019 онд-60, 2020 онд-62 нийгмийн ажилтан тус тус нийгэмшүүлэх ажлын чиглэлээр ажилласан байна.[6]

Гэтэл дээрх тоон үзүүлэлтээс харахад хорих байгууллагын нийгэмшүүлэх ажил хангалттай бус гэж үнэлэгдэх болсон нь нэг талаас нэг нийгмийн ажилтан, сэтгэлзүйчийн хариуцах хоригдлын тоо зохих хэмжээнээс хэт их байгаагаас өөрөөр хэлбэл ШШГБ-ын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив мөрдөгдөхгүй байгаагаас нийгэмшүүлэх ажил чанаргүй, хүртээмжгүй явагдаж байгааг нь үгүйсгэх боломжгүй юм.

Нийгэмшүүлэх ажлын гол онцлог нь нэг талаас хоригдогч нөгөө талаас нийгмийн ажилтан, сэтгэлзүйчийн хоорондын харилцаа, нөлөөллийн ярилцлага, сургалтыг чанартай, хүртээмжтэй явуулсны үндсэн дээр дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт зуршлаас нь татгалзуулах чухал үүрэг гүйцэтгэх юм.

Илтгэлийн гол сэдэв хорих ял эдлүүлэх ажиллагааны нийгэмшүүлэх ажлын талаар бичих болсон шалтгаан нь өөрийн судалгааны ажлын сэдэвтэй шууд холбоо хамааралгүй ч өнөөгийн тулгамдаж буй зарим асуудал нь огтлолцож байгаа тул судлаачийн зүгээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар хийгдсэн 2015-2020 оны хооронд “Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн шинжилгээ” судалгааны тайланд үндэслэн өөрийн байр суурийг илэрхийлэхийг зорьлоо.

Энэхүү судалгаа хорих ял эдэлж буй хоригдлуудаас сонгон зөвхөн урьд хорих ял эдэлж байсан тайланд хийгдсэн хорих байгууллагын


[5] Д. Дамдинцэрэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй зарим асуудал.-// “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэл” ЭШХ-ын эмхтгэл. УБ.,2021.т.14

[6] Б.Алтангэрэл, М.Хүрэлбат, А.Жаргалзаяа “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ” судалгааны тайлан. УБ.,2020

нийгэмшүүлэх ажлын 1289 буюу нийт хоригдлын 30.2 хувиас нийгэмшүүлэх ажлын үр нөлөөний талаар судалгаа авагдсан байна.

Хорих ангид явуулж буй нийгэмшүүлэх ажилд тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх зорилго бүхий асуулгыг хорих ангийн 50 нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдээс авсан судалгааг тоймлон харуулбал:

Мэргэжлийн нийгмийн ажилтны судалгаа



Үүнээс үзэхэд нийгэмшүүлэх ажлыг мэргэжлийн бус ажилтан хариуцан явуулж байгаа нь давамгай байгааг харж болохоор байна.

Нийгэмшүүлэх болон сэтгэл зүйн үйлчилгээнд тулгамдаж буй асуудлын талаар нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нараас авсан асуулгад[7]:

- Орон тоог жишиг норматив нийцүүлэх, шинэчлэн тогтоох -37 хувь
- Сургалт зохион байгуулах төсөв хөрөнгө байхгүй-0,2 хувь
- Сургалт зохион байгуулах мэргэшсэн багш дутагдалтай- 0,2 хувь
- Мэдээллийн сан үүсгэж, зөвхөн цахимаар хийх-0,1 хувь
- Гарын авлаг материал дутмаг-0,07 хувь
- Алба хаагчдад дэмжлэг үзүүлэх сэтгэл зүйчийг бий болгох-0,02 хувь
- Гадаад орнуудын туршлага судлах- 0,02 хувь


Уг асуулгын дүнтэй холбогдлуулан судлаачийн зүгээс өөрийн судалгааны сэдвийн хүрээнд тулгамдаж буй асуудлын огтлолцлолыг шигтгэж өгөхийг зорьлоо.

Судалгаанаас үзэхэд хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарын ажлын ачаалал ихтэйгээс хүртээмжгүй нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж байгааг харж болохоор байна. Гэтэл үүн дээр нэмээд Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.2.2 дахь заалт, Хууль зүй дотоод хэргийн

[7] Б.Алтангэрэл, М.Хүрэлбат нар. Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн шинжилгээ 2015-2020.УБ., 2020 он. 127 дахь тал


сайдын 2017 оны А/73 дугаар тушаалаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журам”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын даргын 2020 оны А/103 дугаар тушаалаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалт зохион байгуулах журам”-ын дагуу Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийг давхар хариуцан ажиллаж байгаа нь аль аль талдаа хүртээмжгүй, үр нөлөө багатай нийгэмшүүлэх ажил болж байгааг дурьдах нь зөв байх.

Судалгааны ажлын явцад 1293 хоригдлоос “Та хорих ангид явуулж буй нийгэмшүүлэх ажлын хэрхэн ойлгодог вэ? гэсэн асуултанд




Үүнээс үзэхэд хоригдлууд дийлэнх нь нийгэмшүүлэх ажил гэж юу болох, ямар учраас тухайн ажлыг явуулах ёстой талаар нэгдсэн ойлголт байхгүй байгааг харж болохоор байна.

Хорих ангид явуулж буй нийгэмшүүлэх ажлын хүрээнд хийгдэж буй сургалттай холбоотой **“Хорих ангид зохиогдож буй сургалтыг хэрхэн үнэлдэг бэ”** гэсэн асуулгын дүнг харуулбал:



Асуулгын дүнгээс харахад 899 буюу 70 хувь нь сайн, 309 буюу24 хувь нь дунд зэрэг, 77 буюу 6 хувь нь муу гэж хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан хоригдлуудаас **“Та хариуцсан нийгмийн ажилтныхаа үйл ажиллагаанд ямар дүн өгөх бэ”** гэсэн асуулгын дүнг харуулбал



Үүнээс үзэхэд 991 буюу 77 хувь нь сайн, 234 буюу 18 хувь нь дунд, 60 буюу 5 хувь нь муу гэж хариулсан хэдий ч нийт улсын хэмжээний 21 хорих ангийн 2015-2020 оны нийгэмшүүлэх ажлын чиглэлээр хийгдсэн тайлан, мэдээ болон нийгмийн ажилтан, нийгмийн ахлах ажилтаны албан тушаалын тодорхойлолтод хийгдсэн дүн шинжилгээгээр:

Хорих байгууллага дахь нийгэмшүүлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөө, гэрээг онолын үндэслэлгүй, оновчгүй төлөвлөх, хэрэгжиж буй хөтөлбөр төлөвлөгөө, гэрээний хэрэгжилтэд явцын үнэлгээ хийгдэдгүй, нийгэмшүүлэх ажлыг мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах хэлбэрээр хязгаарлаж хорих анги дахь нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ нь төдийлөн үр дүнтэй бус байгааг дүгнэж дараах зөвлөмжүүдийг гаргасан байна.

1. Хорих ял эдлүүлэх ажиллагааны үндсэн зорилгоо нийгэмшүүлэх асуудал гэж тодорхойлж, үүнийгээ эрх зүйн зохицуулалтын хүрээнд баталгаажуулах
2. “Төрөөс нийгмийн ажлын талаар баримтлах бодлогын баримт бичиг”-т ял эдлэгсдийг нийгэмшүүлэх асуудлыг тусгуулах санал гаргах
3. Нийгэмшүүлэх ажлыг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтыг “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх заавар” болгон шинэчлэн боловсруулснаар хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийг хамруулан хөрөнгө санхүүтэй холбоотой

асуудлыг шийдвэрлэхийг тусган Нийгэм, хамгаалаллын болон Хууль зүйн асуудал эрхэлсэн Сайд нарын хамтарсан тушаалаар батлуулан улсын хэмжээнд дагаж мөрддөг байх.

4. Хорих байгууллагад зорилтот бүлэгт тохирсон хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх
5. Хоригдолд боловсролыг албан болон албан бус сургалтаар эзэмшүүлэх хүрээнд ерөнхий боловсролын, мэргэжлийн боловсролын, амьдрах ухааны гэсэн төрлөөр дагнасан хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хөтөлбөр хэрэгжүүлэх.
6. Хорих ял эдлүүлэх албаны Нийгэм, сэтгэл зүйн хэлтэс нь нийгэмшүүлх ажлын хөтөлбөрүүдийг боловсруулан нийгмийн ажилтнуудыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах.
7. Нийгмийн ажилтнуудын ажлын байрны үйл ажиллагаа, чиг үүрэг гүйцэтгэлд мониторинг хийн аттестачлан, мэргэшсэн нийгмийн ажилтан- сэтгэл зүйчийн нөөцийг бий болгох[8].

Дүгнэлт

Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын хүрээнд дараах асуудал дээр анхаарлаа хандуулбал зүйтэй хэмээн судлаачийн зүгээс өөрийн санал дүгнэлтийг гаргаж байна.

1. “Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн шинжилгээ” судалгааны тайланд авагдсан тоо баримтаас харахад нийгэмшүүлэх ажлыг ихэвчлэн мэргэжлийн бус хүн явуулж байгааг харж болохоор байна. Хичнээн сайхан төсөл хөтөлбөрүүийг мэргэжлийн бус хүн хэрэгжүүлээд бидний хүсээд байсан үр дүн гарахгүй. Нийгмийн ажил нь өөрөө шинжлэх ухааны түвшний мэргэжлийн үйл ажиллагаа байдаг тул мэргэжлийн албан хаагч зайлшгүй байх шаардлагатай байна. Бэлтгэгдсэн хүний нөөцийн хувьд бололцоо байна. Ажлын байраар хангагдаагүй, нөөцөд бүртгэлтэй ШШГЕГазрын захиалгаар ДХИСургуульд мэргэжлийн нийгмийн ажилтан-сэтгэл зүйчээр бэлтгэгдсэн 2020 оны 13 төгсөгчдийг ажлын байраар хангах.
2. Орон тоог жишиг норматив нийцүүлэн, шинэчлэн тогтоож хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйчдийн ажлын ачааллыг

[8] Б.Алтангэрэл, М.Хүрэлбат нар. Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн шинжилгээ 2015-2020.УБ., 2020 он. 183-184 дэх тал

тэнцвэржүүлснээр нийгэмшүүлэх ажлын үр нөлөө, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дэргэд нийгэм сэтгэлзүйн нэгжтэй болсноор Хорих ял эдлүүлэх албаны дэргэдэх Нийгэм-сэтгэл зүйн хэлтсийн ачаалал багасаж нийгэмшүүлэх ажлын чанар, хүртээмж сайжирч. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар нийгэмд гарч байгаа тодорхой төрлийн давтамжтай үйлдэгддэг гэмт хэргийг бууруулахад зөвхөн Цагдаагийн байгууллагын оролцоо биш бусад төрийн байгууллагууд хууль тогтоомжинд заасан чиг үүрэг бүхий ажлаа дор бүрнээ хуулийн дагуу, хүртээмжтэй, чанартай явуулснаар улс орон нийгмээрээ айх айдасгүй, амар тайван амьдрах бололцоотой юм.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ҮҮРЭГ ОРОЛЦОО, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭДЭНД ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДЛУУД

Э.ТЭМҮҮЛЭН

Товч агуулга: Монголын төр олон нийтийн аюулгүй байдлыг хангахын тулд гэм буруутай этгээдийн хэргийг шүүн хэлэлцэж шүүхээс хорих ял оногдуулсаар ирсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хууль сахиулах үйл ажиллагааны гэмт хэрэгтэй тэмцэх салшгүй бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд нийгмийн аюулгүй, тогтвортой байдал, иргэдийн амгалан тайван байдлын төлөө зүтгэдэг юм. Үүний нэг илрэл нь хорих байгууллагын харуул хамгаалалтын тасралтгүй үйл ажиллагаа юм. Харуул хамгаалалтын салшгүй нэг хэсэг нь ахлагч бүрэлдэхүүн билээ.

Ахлагч бүрэлдэхүүн бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гол хөдөлгөгч хүч юм.

Abstract: To ensure public safety, the Mongolian government has continued to prosecute and impose imprisonment. The judiciary, as an integral part of law enforcement, fights for social security, stability, and the well-being of citizens. One manifestation of this is the continuous security of prisons. An integral part of the guard is the senior staff.

The senior staff is the main driving force of the judiciary.

Түлхүүр үгс: Хорих байгууллага, ахлагч бүрэлдэхүүн, харуул хамгаалалт, хорих ял эдлүүлэх ажиллагаа, үүрэг гүйцэтгэл

Keywords: Prisons, senior staff, security guards, imprisonment and duties

1. Хорих байгууллагын харуул хамгаалалт, ахлагч бүрэлдэхүүний талаар

Хорих байгууллага нь зүрх зүсч, сэтгэл сэмлэсэн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд буюу эрүүгийн элементүүдийг гагцхүү шүүхээс оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлж, тогтоосон орон зайд нийтээс тусгаарлан тасралтгүй харуул хамгаалалтын хяналт тавих үүргийг хуулийн хүрээнд

хэрэгжүүлэх, төрөл мэргэжлийн олон албадын боловсон хүчний бүтэц, түүний хангалтын түүхэн замнал нь хууль хяналтын бусад байгууллагаас ялгагдах онцлогтой. Энэ нь хорих байгууллага зөвхөн төрийн байгууллага төдийгүй боловсрол, эрүүлийг хамгаалах, хангалт үйлчилгээ зэрэг олон салбарын ажил хариуцан явуулдаг. Хорих байгууллагын харуул хамгаалалтын зорилго нь: Хоригдож буй этгээдийг олон нийтээс тусгаарлан тэднээс дахин давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, үйлдсэн хэргийг илрүүлэх, таслан зогсоох, холбогдох хууль, хорих ангийн дотоод журам, цагийн хуваарийг чанд мөрдүүлэх, хорих анги, ялтны болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа идэвхитэй хэрэгжсэн байхыг хэлнэ. Дээрх үүргийг хэрэгжүүлэх явцад хорих ангийн харуул хамгаалалтад хоригдож буй этгээдийн зүгээс албан хаагчийн үүрэг гүйцэтгэлт, улмаар албаны үйл ажиллагаанд нөлөөлөхийг оролдох, хэл амаар доромжлох, өөртөө ашигтай шийдвэр гаргуулахыг /ял завших/ эрмэлзэх, албан хаагчийг янз бүрийн аргаар өөрийн эрхшээлдээ оруулахыг хичээх, албан хаагчийн эрүүл мэндэд халдах бусдын амь насыг хохироох, харуул хамгаалалтад санаатай хүндрэл учруулах гэх мэт хорих ангийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах зорилго бүхий үйлдлийг байнгын буюу тасралтгүй шинжтэйгээр үйлдсээр[1] байна. Энэ бүхэнтэй хорих байгууллагын ахлагч бүрэлдэхүүн байнга тулгарч байдаг.

Хорих байгууллагын ахлагч бүрэлдэхүүний оролцоотойгоор харуул хамгаалалтыг хэрхэн зохион байгуулж байсан талаар товчхон дурьдах шаардлагатай гэж үзэж байна.

1921 оноос өмнө буюу Манжийн хаанчлалын үе болон Богд хаант Монгол улсын үед хууль цааз зөрчсөн хаад, ноёдыг эсэргүүцсэн, татвар төлөөгүй иргэдийг газар нүхэнд болон хар гэрт хорьж хуяг, харгалзагч нараар харуул хамгаалалт[2]-ыг нь хангуулдаг байжээ.

1921 оны 08 дугаар сарын 30-нд Яамдын сайд, засгийн газрын зөвлөх, эрхэлсэн түшмэд нар хурлдаж гянданг Цагдан сэргийлэхийн хуягууд хамгаалж байсныг өөрчлөн шүүх яамны харьяа Засан сайжруулах

[1] Б.Нямгомбо. “Монгол улс цаазаар авах ялаас татгалзсанаар хорих байгууллагын аюулгүй байдалд гарч болзошгүй сөрөг хандлага” илтгэл Шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл №01. УБ.2012 он

[2] Б.Нямгомбо, Ч.Хүрэлбаатар “Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаа” УБ хот. 2013 он 9 дэх тал

байгууллагад дагнан хариуцуулж, хэрэгтэн, хоригдож буй этгээдийг Монгол цэргийн хуягуудаар харгалзуулан хамгаалуулахаар болсон.

1925 оны 05-р сарын 09-ны өдрийн 10-р хурлаар “Их гянданг сайжруулах тухай 16 зүйл бүхий дүрэм”-ийг засгийн газраас баталсан. Энэ дүрмээр хоригдож буй этгээдэд хяналт тавих, орчны гэрэлтүүлгийг сайжруулах, шалган нэвтрүүлэх хуягын чиг үүргийн талаар нэлээд анхаарчээ. Дурьдвал:

Гяндангийн хуягуудаас хоригдож буй этгээд нэг бүрийг өдөр тутам бүртгэж байх, шүүх яамнаас авсан зөвшөөрлийг үндэслэн 8-11 цаг, 14-16 цагт гяндангийн ерөнхий даргын дэргэд эргэлт уулзалтыг зохион байгуулах, өдөр шөнийн цагт үргэлжид хуяг нэгэн хүнийг ээлжээр хоригдож буй этгээдийн суух байшин бүрийн дотоод, гадаадыг цагдан байцаалтыг сэргийлэн сахиулах чиг үүргийг зааж өгсөн байна.

1930 оноос эхлэн “Гяндан салаа”-г “Засан сайжруулах газар” гэж нэрлэн энэ үеэс хоригдож буй этгээдийг харж хамгаалах албаны хүмүүсийг хуяг гэж нэрлэж байсныг өөрчилж харгалзагч[3] болгов.

Бага бүрэлдэхүүн буюу хянагч нарыг хилийн цэрэг, тусгай батальон, Ардын цэргээс 10-80 хүртэлх цэрэг, дайчдаас сонгон авч тодорхой хугацаагаар бэлтгэдэг байлаа.

Баримт-1 1973 оны 10 дугаар сард Батлах хамгаалах яамнаас 79 цэрэг авч 12 ангид 1-15-аар нь хувиарлан БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 347 дугаар тогтоолын заалтыг хэрэгжүүлсэн байна.

1931, 1966, 1981, 1993, 1994, 1995, 1996, 2002, 2017 онд батлагдан гарсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад хяналт, харуул хамгаалалтын зохион байгуулалтын талаар зүйл заалт болон үйл ажиллагаа нь улам боловсронгуй болон хөгжсөөр байна.

1921-2002 он хүртэл “Гяндан-салаа”-“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар” гэсэн өөрчлөгдсөн ч бүтцэд нь харуул хамгаалалтын бие даасан алба ажиллаж түүнд нь бага бүрэлдэхүүн буюу ахлагч бүрэлдэхүүн байсаар байна.

И.Дамбажав “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичигт[4]

[3] А.Лхагваа “Гяндан салаанаас Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар болж хөгжсөн түүхэн замнал” УБ хот. 2001 он 11-12 дох хуудасны тал

[4] И.Дамбажав “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг” УБ хот. 2010 оны 568, 600 дахь хуудасны тал

Харуул гэж: Тогтоосон газар, обьект, цэгт хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлж буй ажилтан гэж тус тус тайлбарлажээ.

Өнөө цагт ахлагч бүрэлдэхүүн мэргэжлийн ур чадвар, оюун санаа, сэтгэлгээний чадамж, цэргийн албаны мэргэжил, боловсролоороо ихээхэн чадварлаг болон хөгжсөөр байна.

2. Ахлагч бүрэлдэхүүнд тулгамдаж буй асуудал

Хоригдож буй этгээд нь хорих байгууллагын удирдлага, офицер болон ахлагч бүрэлдэхүүнд ялгамжтай ханддаг. Ахлагч бүрэлдэхүүний зүгээс хоригдож буй этгээдэд хууль ёсны шаардлага тавьсныхаа төлөө хэл амаар доромжлуулах, амь нас, эрүүл мэндээрээ хохирох, дарамт сүрдүүлэгт байнга өртдөг.

Баримт-2: 2014 оны 4 дүгээр сарын 27-нд ШШГЕГ-ын харьяа Хорих 409 дүгээр ангид хоригдож буй этгээд нь тоо бүртгэлийн ажилтан эмэгтэй алба хаагчийг хэл амаар доромжилжээ. Түүнийг болиулахаар очсон дэслэгч залууг өөр тийш харах үед нүүр лүү нь нэг бус удаа цохиод авсан тухай мэдээллийг тухайн үед олон нийтэд[5] хүргэж байсан.

Баримт-3: 1996 оны 01 дүгээр сарын 03-04-нд шилжих шөнө Авдрантын гянданд хоригдож байсан гурван этгээд хоёр хянагч, хоригдож байсан гурван эмэгтэй этгээдийн амь насыг нь хөнөөн оргосон. Тухайн үеийн байдлаас авч үзэхэд хорих ангийн ажилтнууд дүрэм журмаа баримталж биелүүлдэггүй, сонор сэрэмжгүй, назгай байдалдаа дассны улмаас гэж үзэж болох ч нөгөө талаас хоригдож буй этгээдийн дарамт, сүрдүүлэг орсон гэж үзэж байна

Баримт-4: 2009 онд Дамжин өнгөрүүлэх 401 дүгээр ангид хоригдож байсан этгээд Н нь хянагчийг хутгалан оргон зайлсан.

Баримт-5: Соц нийгмийн үед Төв аймгийн Баян сумын нутаг Мааньт дахь чанга дэглэмтэй хорих ангиас 1980 оны 07 дугаар сарын 17-нд хоригдож байсан 9 этгээд тэр өдөр үүрэг биелүүлж байсан харуулын алба хаагчдыг хүч түрэн амь насанд нь халдаж хүлээд зугтжээ.

Хоригдож буй этгээд нарт хорих байгууллагын хэмжээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэг нэгжлэг хийхэд хоригдолд хориглох эд зүйлс болох гар утас, хутга, мэсний шинжтэй иртэй үзүүртэй зүйлс хураан авч

[5] Г.Равжаа “Өнөөдөр” сонин 2015.06.04

устгадаг ч хоригдогч, хоригдлууд хориотой эд зүйлсийг ямар нэгэн байдлаар олж авах, хадгалах, хэрэглэх явдал гарсаар байна.

2018 онд 381 хоригдол зөрчил гаргасан ба хорих ангид ял эдэлж буй хоригдлын 290 зөрчил, 2 гэмт хэрэг, цагдан хорих байранд хоригдогсдоос 106 зөрчил, 3 гэмт хэрэг тус тус гарсан байна.

Дээрх баримт, нөхцлөөс харахад хоригдож буй этгээдтэй тулж ажилдаг ахлагч бүрэлдэхүүнд амь нас, эрүүл мэндэд нь баталгаа өгөх ямар ч боломжгүй.

Дараагийн асуудал нь хорих байгууллагын ахлагч бүрэлдэхүүн хоригдож буй этгээдтэй хамт хорих байранд цоожлуулан ажилладаг нь сонгох, сонгогдох эрхээ л эдэлж байгаа болоч бусдаар бол хоригдогч, хоригдолтой адил орчин нөхцөлд ажил үүргээ гүйцэтгэж байгаа нь сэтгэл санааны тогтворгүй байдлыг бий болгодог.

Хоригдож буй этгээдийн орилоон хашгираан, хараалын үгс шидлэх тэр л дүр төрхийг харж, дуу авиаг сонсох тийм ч амар биш. Аав ээж нь бурхан болсон хоригдож буй этгээдүүдэд ямар нэг муу мэдээ дуулгах, эргэлт уулзалтыг нь оруулахгүй өдөр ирээд нулимс дүүрэн нүдтэй буцаж байгаа тэдний ар гэрийнхнийг үдэх зэрэг нь өдөр тутам тохиолддог бэрхшээлүүдийн нэг бөгөөд сэтгэл санааны эмзэг байдалд оруулдаг.

Гурав дах асуудал нь тангараг өргөсөн гэхээр л ар гэргүй амьдралгүй мэт зүтгэ гэсэн үг биш юм. Иймд ажиллах нөхцөл, нийгмийн хамгаалалын талд хүндрэлтэй асуудлууд олон байгаагийн нэг нь орон байрны асуудал юм.

“Орон сууцанд орох боломж тун бага” бөгөөд ахлагч бүрэлдэхүүний цалингийн хэмжээ бага байдаг, өрхийн гэр бүлийн гишүүдийн тоо олон байдгаас хаанаа ч хүрэхгүй байх, цалингаас цалингийн хооронд ажиллаж байх нь олонтой.

Энэ нь эргээд эдийн засгийн баталгаа алдагдаж байгаагийн илрэл. Уг нь төрийн тусгай албанд үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүсийн нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгааг төр хариуцах ёстой гэтэл чадахгүй байгаа нь харамсалтай.

Дөрөв дэх асуудал нь хамгаалалтын ажилтны орон тоог Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “ШШГБ-ын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”-д заасны дагуу нэмэгдүүлэх.

Тав дахь асуудал нь хамгаалалтын ажилтны сул орон тоог нөхөх, батлагдсан жишиг нормативын дагуу нэмэгдүүлээгүй байгаа нь тулгамдаж буй гол асуудлын нэг юм.

Учир нь Хууль Сахиулахын их сургуулийн Ахлагчийн сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн сургууль “Харуул хамгаалалтын албаны ажилтан” бэлтгэх дамжаанд 60-80 иргэнийг сурган хорих ангиудад томилдон ажиллуулдагч сул орон тоог нөхөж чаддаггүй мөн ажиллах орчин нөхцлийн талаар бодит ойлголтгүй байдгаас шалтгаалан 40 хүртэл хувь нь ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгдөг байна.

3. Судалгаа

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа бүрэлдэхүүний талаар

Хүснэгт-1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа алба хаагчдыг ангилан авч үзэхэд

	Бүрэлдэхүүн	Тоо	Хувь
1	Офицер	1204	38%
2	Ахлагч	1632	52%
3	Энгийн	300	10%

график-1



2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа ахлагч бүрэлдэхүүний хүйсийн байдлын талаар

Хүснэгт-2 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа ахлагч бүрэлдэхүүнийг хүйсийн байдлаар ангилан авч үзэхэд

	Ахлагч бүрэлдэхүүний хүйс	Тоо	Хувь
1	Эрэгтэй	1221	75%
2	Эмэгтэй	411	25%

график-2




3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас алба хаагчдад үзүүлсэн тэтгэмж, тусламжийн талаар

Хүснэгт-3 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас алба хаагчдад үзүүлсэн тэтгэмж, тусламжийг ангилан авч үзэхэд /сүүлийн 3 жилийн байдлаар/

	Судалгаанд хамруулах он	Офицер	Ахлагч
1	2015 он	6	3
2	2016 он	4	3
3	2017 оны 03 дугаар сарын 02-ны байдлаар	3	2

график-3



ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2017 оны 3 дугаар сарын 02-ны байдлаар гаргасан статистик, судалгаанаас харахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 3136 албан хаагч ажиллаж байсан бөгөөд нийт бие бүрэлдэхүүний 1204 буюу 38%-ыг офицер, 1632 буюу 52%-ыг ахлагч, 300 буюу 10%-ыг энгийн ажилтан тус тус эзэлж байна.

Ахлагч бүрэлдэхүүнд 1632 алба хаагчийг хүйсийн байдлаар ангилахад 1221 буюу 75%-ыг эрэгтэй, 411 буюу 25%-ыг эмэгтэй албан хаагч тус тус багтаж байна. Сүүлийн 3 жилийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас офицер 13, ахлагч 8 албан хаагчид тэтгэмж, буцалтгүй тусламж үзүүлсэн.

Дээрх судалгаан дээрээс харахад ахлагч бүрэлдэхүүн бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гол хөдөлгөгч хүч бөгөөд нийт бие бүрэлдэхүүний 52%-ыг эзлэж байгаа нь хууль сахиулахын үйл ажиллагаанд ахлагч бүрэлдэхүүний үүрэг оролцоо их байгааг харуулж байна.

Дэвшүүлж буй санал-1: Ажиллах нөхцөл, нийгмийн хамгааллыг сайжруулах асуудалд төр анхаарал хандуулах

Дэвшүүлж буй санал-2: Хоногийн харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж буй алба хаагч нарыг сэтгэл заслын эмчилгээнд хамруулах, сэтгэл зүйг төлөвшүүлэх

Дэвшүүлж буй санал-3: Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “ШШГБ-ын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”-д заасны дагуу ахлагч бүрэлдэхүүний орон тоог нэмэгдүүлэх, сурган бэлтгэж буй алба хаагчдын чадавхийг дээшлүүлэх, сайтар судлан бэлтгэх.

Дэвшүүлж буй санал-4: Олон нийт буюу иргэдэд хорих байгууллагын талаар сөрөг мэдээлэл, хандлага бий болгож буй цахим орчинд, нэвтрүүлэгт тавигдаж буй мэдээлэлд хяналт тавих, хориглох

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ:

1. Төрөөс ажиллах нөхцөл, нийгмийн хамгаалалын асуудалд анхаарал хандуулж урт хугацааны зээл, хөнгөлөлттэй нөхцлөөр орон сууцаар хангах

2. Хоногийн харуул хамгаалалтын харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж буй ахлагч бүрэлдэхүүнийг улиралд нэг удаа сэтгэл заслын эмчилгээнд хамруулах

3. Ахлагч бүрэлдэхүүний албаны бэлтгэл, мэдлэг боловсролыг дээшлүүлэхийн тулд 2 жилд нэг удаа төрөл, мэргэшлийн холбогдолтой сургалтад нэгдсэн байдлаар хамруулах

4. Тэтгэвэрт гарахад нь нийгэм, аж ахуйд нэн чухал хэрэгцээ шаардлагатай мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулах нэгдсэн бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх

5. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “ШШГБ-ын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”-д заасны дагуу хамгаалалтын ажилтан /биечилсэн хяналт/ -ыг хорих ангид 20 хоригдол тутамд 1, Сургалт-Хүмүүжлийн тусгай байгууллагад 15 хоригдол тутам 1, цагдан хорих байранд 10 хоригдол тутамд 1, баривчлах төвд дүрс бичлэгийн хяналтын ажилтан, холбоочин ээлж бүрт 1 зэргээр орон тоог нэмэгдүүлэх

6. Нийгэм буюу иргэдийн дунд хорих байгууллагын талаарх буруу ташаа ойлголт өгч буй цахим орчин, олон нийтийн нэвтрүүлэг, уран сайхны кино зэргийг анхааралдаа авч сөрөг хандлага, буруу ташаа мэдээлэл олон нийтэд төрүүлэхгүй байх.

7. Хоригдлыг нийгэм, сэтгэл зүйн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хоригдлын гэмт хэрэг, зөрчил үйлдэх болсон шалтгаан, ар гэрийн нөхцөл байдлыг сайтар судлан, хянаж, харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын хяналтыг өндөржүүлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэснээр ахлагч бүрэлдэхүүний ажилдаа хандах хандлага эрс сайжирч, үүрэг гүйцэтгэл хэвийн явагдана гэж үзлээ.

Хоригдож буй этгээдийн зүй бус үйлдлийг хүний эрх нэрээр давраалгүй, эдлэх ёстой эрхийг эдлүүлж, үүрэг ёстой хариуцлагыг үүрүүлж, хорих байгууллагын салшгүй нэг хэсэг болсон ахлагч бүрэлдэхүүний амь нас, эрүүл мэнд, ажиллах нөхцөл, нийгмийн хамгаалалын баталгаанд Монголын төр анхааралаа хандуулах цаг болжээ.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” 2002 он
2. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам” УБ хот. 2002 он
3. А.Лхагваа “Гяндан салаанаас Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар болж хөгжсөн түүхэн замнал” УБ хот. 2001 он

4. И.Дамбажав “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг” УБ хот. 2010 он
5. Б.Нямгомбо. “Монгол улс цаазаар авах ялаас татгалзсанаар хорих байгууллагын аюулгүй байдалд гарч болзошгүй сөрөг хандлага” илтгэл Шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл №01. УБ хот. 2012 он
6. Б.Нямгомбо, Ч.Хүрэлбаатар “Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаа” УБ хот. 2013 он
7. Г.Равжаа “Өнөөдөр” сонин. УБ хот. 2015 он
8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын статистик судалгаа” 2017 он